



ЗУРГААН НАСТНЫГ СУРАЛЦАХУЙД БЭЛТГЭХ САЙН ТУРШЛАГУУД



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



Save the Children

**ЗУРГААН НАСТНЫГ СУРАЛЦАХУЙД
БЭЛТГЭХ САЙН ТУРШЛАГУУД**

2018 он

DDC

**ЗУРГААН НАСТНЫГ СУРАЛЦАХУЙД
БЭЛТГЭХ САЙН ТУРШЛАГУУД**

ISBN:

"НЭГДҮГЭЭР АНГИЙН СУРАГЧДЫН СУРАЛЦАХ ЧАДВАРЫГ ДЭМЖИХЭД ЧИГЛЭСЭН СУРГУУЛИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ" ТӨСӨЛ

2015-2018 он



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



From
the People of Japan



Save the Children
セーブ・ザ・チルドレン



☑ ТӨСЛИЙН ЗОРИЛТУУД:

- 1 Бага ангийн багш нарын мэдлэг, ойлголт чадварыг сургалтад хамруулах замаар дээшлүүлэх
- 2 Нэгдүгээр ангийн хүүхдийн суралцах чадварыг дэмжих сургуульд дасан зохицоход туслах бүтэц, тогтолцоо бүрдүүлэх
- 3 Хүүхдийн суралцах чадварыг дэмжих талаар эцэг эх/ асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд зориулсан сургалт, сурталчилгааны ажлууд зохион байгуулах
- 4 Төслийн үр дүнд амжилттай хэрэгжсэн загвар, үйл ажиллагааг сурталчлах, төрийн бодлогод тусгах

🎯 ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Уг төсөл нь нийслэлийн Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн зорилтот төрийн өмчийн сургуулиудын нэгдүгээр ангийн сурагчдын "суралцах чадвар"-ыг дээшлүүлэх, тэднийг сургуульд дасан зохицоход туслах зорилготой.

👤 ТӨСЛИЙН ҮР ШИМИЙГ ХҮРТЭГСЭД:

Шууд: 28,664 Шууд бус: 121,500

🏠 ТӨСӨЛД ХАМРАГДАЖ БАЙГАА СУРГУУЛИУД:

Чингэлтэй дүүрэгт: 117, 49, 61, 39, 17, 37, 57, 72-р сургууль

Баянзүрх дүүрэгт: 87, 79, 85, 92, 97-р сургууль, Шавь, Амгалан, Баянзүрх Цогцолбор сургууль

Сонгинохайрхан дүүрэгт: 67, 104, 107, 122, 65, 76, 105, 124-р сургууль

ГАРЧИГ

Өмнөх үг	5	Төсөлд хамрагдсан сургуулиуд: Орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах	32
49-р сургууль: Нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөр, монгол хэлний хичээлийн сургалтын үйл ажиллагаанд зурагт үзүүлэн, тараах материал ашиглах	6	Төсөлд хамрагдсан сургуулиуд: Сургуулийн орчинд нэгдүгээр ангийн сурагчдад зориулсан тэмдэг, тэмдэглэгээг бий болгох	34
65-р сургууль: 1-р ангийн Бэлтгэл хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх багш нарын заах аргын нэгдлийн туршлага	8	37, 117-р сургуулиуд: Сургуультай танилцах аялал	36
85-р сургууль: Эргүүлдэг үеийн хүрд	10	37-р сургууль: Нэгдүгээр ангийн сурагчдад зориулсан номын булан	38
79-р сургууль: Багшийн хөгжлийг дэмжсэн мэргэжил дээшлүүлэх сургалтын сургуулийн тогтолцоог бий болгох	12	Шавь цогцолбор сургууль: Нэгдүгээр ангийн сурагчдад зориулсан хүлээлгийн танхим	40
79-р сургууль: Анги даасан багш нар хүүхдийн хувийн мэдээллийг үр дүнтэй ашиглах	15	92-р сургууль: “Цүнх” аян	42
65-р сургууль: Хамран сургах тойргийнхөө цэцэрлэгтэй хамтран сургууль-цэцэрлэгийн залгамж холбоог хангаж ажиллах чиглэлээр хэрэгжүүлсэн туршлага	18	39-р сургууль: Уншлагын хөзөр-Ширээний тоглоом	44
67-р сургууль: Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах аргазүй	20	79-р сургууль: Нэгдүгээр ангийн сурагчдаар “Жижиг ном” хийлгэх	46
17-р сургууль: Бага, дунд, ахлах ангийн багш нарын хамтын ажиллагааг дэмжих замаар “Нэгдүгээр ангийн багш нарт сургалтын хэрэглэгдэхүүн хийж туслах аян”	22	Шавь цогцолбор сургууль: “Миний зугаатай амралт” зурагт даалгаврыг хэрэгжүүлсэн туршлага	48
Төсөлд хамрагдсан сургуулиуд: Нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн өөрийн үнэлгээний аргазүй	24	117-р сургууль: Тоглоомын аргаар нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дээшлүүлэх	50
Төсөлд хамрагдсан сургуулиуд: Нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургуулийн засаглал	26	105-р сургууль: Нэгдүгээр ангийн сурагчдаар шүлэг, оньсого чээжлүүлэх	52
		65-р сургууль: Эцэг эхийн хурал болон ганцаарчилсан уулзалтыг үр дүнтэй зохион байгуулах	54
		72-р сургууль: Ангийн эцэг эхийн зөвлөлийг байгуулах	57
		Амгалан цогцолбор сургууль: Цэцэг ургуулах аян	59

ӨМНӨХ ҮГ

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Хөтөлбөр нь 2015 оны 3 дугаар сараас эхлэн “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхыг бэхжүүлэх нь” төслийг Нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн Ерөнхий боловсролын 24 сургууль дээр хэрэгжүүлсэн билээ.

Манай төсөл нэгдүгээр ангийн хүүхдийн дасан зохицох, суралцах чадварыг дээшлүүлэх зорилгоор дээрх сургуулиудад хүүхдүүдийг дэмжих бичил орчин, тогтолцоо бүрдүүлэх, бага ангийн багш нарын энэ талаарх мэргэжлийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, эцэг эх, асран хамгаалагчдын хүч, оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн юм. Төсөл хэрэгжүүлсэн сургуулиуд маань ч дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ өөр өөрийн сургуулийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн өвөрмөц арга туршлагыг уйгагүй идэвх чармайлтын үр дүнд бий болгосон юм.

Эдгээр сургуулиудын олон арга туршлагуудыг төслийн багийнхан нэгтгэн цуглуулж, шүүн тунгаах, хянан засварлах ажлыг хийж сайн туршлагуудаа эмхэтгэн та бүхний хэрэгцээнд зориулан гаргаж байна.

Энэхүү сайн туршлагын эмхэтгэл маань бусад сургуулиудын зүгээс анхааран судалж үзэх, амьдралд туршин хэрэгжүүлэх санаа бодлыг төрүүлэхүйц сонирхолтой гарын авлага болсон хэмээн найдаж байна.

Таалан соёрхоно уу.

49-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөр, монгол хэлний хичээлийн сургалтын үйл ажиллагаанд зурагт үзүүлэн, тараах материал ашиглах



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Нэгдүгээр ангийн багш нар



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Чингэлтэй дүүргийн 49 дүгээр бүрэн дунд сургуулийн багш Д.Батмөнх

ЗОРИЛГО

Нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөр, монгол хэлний хичээлийн явцад үйл явдлын дүрслэл харуулсан зурагт үзүүлэн, тараах материал ашиглан хүүхдийн хэл ярианы болон өөрийгөө илэрхийлэх, эх зохион ярих чадваруудыг хөгжүүлэх



АРГАЗҮЙ

Бэлтгэл хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулах явцад сургалтын аргазүйн дараах зарчмуудыг ашиглавал үр дүнтэй байдаг. Үүнд:

- 1 Хүүхдэд зориулсан үйл ажиллагааг сонирхолтой, хөгжилтэй хэлбэрээр явуулах.
- 2 Багш хүүхдээс “нээлттэй” асуулт асууж ярилцдаг байх. Нээлттэй асуулт гэдэг нь хүүхэд “Тийм”, “Үгүй” гэх биш харин дэлгэрэнгүй хариулт өгч болох асуултууд юм.
- 3 Хүүхдээр хийлгэх дасгал даалгаврыг олон хэлбэрээр төлөвлөж явуулах.

Бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх үеэр 1-р ангийн бэлтгэл хөтөлбөрийн “Дасгал ажлын дэвтэр” ашигладаг. Энэ дэвтэр дэх хүүхдийн өмнөх төсөөлөл, мэдлэг, чадварт тулгуурласан тоглох, хийж бүтээх, танин мэдэх, харилцааг тусгасан дасгалуудыг хүүхдээр ажиллуулахдаа дээрх зарчмуудыг хэрэгжүүлж болно. Жишээлбэл: “Сургуулийн ертөнцөөр” бүлгийн “Сурагч боллоо” сэдвийг нэг өдөр 4 цагт багтаан үзэх бөгөөд эхлээд хүүхдийн өсөлт хөгжлийг харуулсан зураг дээр хүүхдийг сэдэлжүүлэн ярилцаж “Би сурагч боллоо”, “Сурагч хүний гол хөдөлмөр юу вэ” гэдгийг ойлгуулж, дараа нь цэцэрлэг, сургуулийн ялгааг зураг дээр тайлбарлан ярилцана. Энэ үеэрээ хүүхдэд учир шалтгааныг олуулах, дөхүүлэх, ажиглуулсан зургаас асуух зэргээр төрөл бүрийн “нээлттэй” асуулт тавьж ярилцаж болно.

Энэ мэтчилэн “Тоглоомын ертөнцөөр”, “Үлгэрийн ертөнцөөр” зэрэг бүлэг сэдвүүдийн хүрээнд хүүхэд бүр гараараа хийж бүтээх, тоглох зэрэг бүтээлч үйл ажиллагааг явуулбал үр дүнтэй.

Бэлтгэл хөтөлбөр болон монгол хэлний хичээлийн сургалтын үеэр хүүхдийн үсэг, цифр үзэхэд бэлтгэх, хэл ярианы суурь чадваруудыг сайжруулах зорилгоор үйл явдлын дараалал харуулсан багшийн зурагт үзүүлэн болон хүүхэд бүрт тарааж өгөх хуудас бэлтгэж өдөр тутам ашигласан. Нэгдүгээр ангийн сургалтын болон нэмэлт цагуудаар үйл явдлын дараалал харуулсан зурагт үзүүлэн ашиглан сурагчдаар зурагт үзүүлэнгийн үйл явдлыг логик дэс дарааллын дагуу яриулах, асууж ярилцах, эх зохиолгох зэргээр хүүхэд бүрийг оролцуулсан үйл ажиллагааг тогтмол явуулсан. Үүний дараа сургуулийн хэмжээнд 1 дүгээр ангиудын сурагчдыг хамруулсан “Би уншиж чадна” сэдэвт үйл явдлын дараалал харуулсан зураг дээр ярилцах 2 үе шаттай тэмцээн зохион байгуулж дүгнэсэн. Үүний үр дүнд нэгдүгээр ангийн хүүхэд цаашид үсэг үзээд унших хурд сайжрах, багшийн уншиж өгсөн эхийг хурдан ойлгох, бие даан өөрийн санаагаа илэрхийлэх, зохион бичих зэрэг чадварууд ахидаг нь харагдсан. 2016 оны хичээлийн жилийн эцсийн үнэлгээгээр манай ангийн хүүхдүүд, унших, ярих чадвараар тус бүр 93%-тай шалгуулсан нь үүний нотолгоо юм.



ҮР ДҮН

Нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөр, монгол хэлний хичээлийн явцад хүүхдийн суралцах суурь чадваруудыг дэмжих ялангуяа өөрийгөө илэрхийлэх, бусадтай ярилцах, зураг ажиглаж үйл явдлыг ярих чадваруудыг хөгжүүлснээр сурагчид цаашид цагаан толгой үзэх, монгол хэлний хичээлээр эх унших, багшийн уншсан эхийг хурдан ойлгох, эх зохиож ярих зэрэг чадваруудад түргэн суралцсан.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

1-р ангийн бэлтгэл хөтөлбөр хэрэгжүүлэх үеэр дээрх хүүхдийг зураг харж яриулах чадварыг дэмжихэд ашиглах багшийн зурагт үзүүлэнг төрөлжүүлж бэлтгэх, үйл явдлын дараалал харуулсан зурагт хуудас, тараах материалыг олшруулж бэлтгэх хэрэгтэй. Ингэснээр жил бүр эдгээр сургалтын дидактик материалуудаа ашиглаад явах боломжтой.

65-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

1-р ангийн Бэлтгэл хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх багш нарын заах аргын нэгдлийн туршлага



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Сонгинохайрхан дүүргийн 65 дугаар бүрэн дунд сургууль



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Нэгдүгээр ангийн багш нар

ЗОРИЛГО

Нэгдүгээр ангийн Бэлтгэл хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх



АРГАЗҮЙ

Бэлтгэл хөтөлбөрийн сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад бидний хийсэн ажлыг бэлтгэл, хэрэгжүүлэх, дүгнэх үе шат хэмээн хувааж авч үзэж болох юм.

Бэлтгэл үе шатанд хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө хүүхдийн бүртгэл хийх, эцэг эхчүүдэд зориулсан өртөөчилсөн сургалт явуулах, хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах талаарх эцэг эхийн гарын авлагыг тараах, тэдэнд хүүхэдтэйгээ хэрхэн ажиллах зөвлөмжийг өгөхөөс эхэлдэг. Манай сургуульд 1 дүгээр ангид элсэгчдийн 80 гаруй хувийг дээрх гарын авлагын дагуу зуны турш гэртээ суралцсан хүүхдүүд эзэлж байсан ба хүүхдүүд шүлэг цээжлэх, зурлага зурах зэргээр сурах бэлтгэлээ хангасан нь нэгдүгээр ангийн багшийн ажлыг ихээхэн хөнгөвчилж байсныг хэлэх нь зүйтэй. Мөн хичээл эхлэхийн өмнө буюу 8 дугаар сарын 30-нд “Багштайгаа танилцах өдөрлөг”-ийг сурагчид, эцэг эхчүүдийн дунд, 9 дүгээр сарын 1-нд нэгдүгээр ангийнхныг угтах үйлчилгээг сургуулийн хэмжээнд зохион байгуулсан. Энэ нь тэдэнд сургуульд дасан зохицох эхний шатаа амжилттай даван туулахад тус болсон.

Хэрэгжүүлэх үе шатанд нэгдүгээр ангийн багш нарын секцийн удирдамжийн дагуу ээлжит хичээлийн болон бүлэг сэдвийн боловсруулалт, конспектыг багш бүр боловсруулсан. Тухайлбал, багш сурагчдын хийх үйл ажиллагаа, багшийн өгөх зааварчилгаа, дүгнэлт үнэлгээ гэсэн бүтэцтэйгээр нарийвчлан боловсруулж секцийн ажлаараа ярилцаж баталгаажуулсан. Сургалтын явцад нэгдүгээр ангийн багш нар секцээрээ өдөр тутмын сургалтын үйл явц, хүүхдийн гүйцэтгэлийг тооцож ярилцдаг байсан ба долоо хоног тутам үзсэн бүлэг сэдвийн хүрээнд хүүхдийн чадвар, гүйцэтгэл, төлөвшлийн түвшин, тохиолдож буй бэрхшээл, анхаарах зүйлсийн талаар үнэлгээ дүгнэлт өгч ажилласан.

Мөн дараах зүйлсийг багш бүр анхаарч хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

- Сургалтад хэрэглэх хичээлийн хэрэгслийг (хайч, өнгийн цаас) сурагч нэг бүрээр бэлтгүүлэх
- Хүүхдийн гүйцэтгэлийн үнэлгээнд наадаг цаас бэлтгэж ашиглах /смайлл/
- Нэмэлт гэрийн даалгавар өгөх. Жишээ нь: гар хурууны жижиг булчинг дэмжсэн дүрс будах даалгавар өгч байсан ба үүндээ жишээ харж дуурайн будах, дүрс нөхөж будах, өөрөө сэтгэж будах зэргээр даалгаврыг төрөлжүүлж өгөх
- Хичээл хоорондын завсарлагааны үеэр Бэлтгэл хөтөлбөрийн “Багшийн зөвлөмж”-д тусгасан хүүхдийн хөдөлгөөнт дасгалуудыг сурагчдаар тогтмол хийлгэх

Үүнээс гадна бэлтгэл хөтөлбөрийн “Дасгал ажлын дэвтэр”-ийг үр дүнтэй ашиглахдаа дараах зааврыг багш бүр дагаж мөрдсөн.

- Багшийн зүгээс хүүхдийн дасгал, даалгаврын гүйцэтгэлийг нарийвчлан ажиглаж хүүхэд бүр дээр тэмдэглэл хөтлөх. Тэмдэглэл дээрээ үндэслэн сурагчдад тохиолдож буй бэрхшээлийг тогтоож, туслах арга замаа төлөвлөх
- Сургалтын явцад хоцорч яваа цэцэрлэгт хамрагдаж чадаагүй хүүхэд, зарим сурах бэрхшээлтэй хүүхдүүдтэй ганцаарчлан ажиллах, эцэг эх, гэр бүлтэй нь хамтран анхаарч туслах
- Дасгал, даалгаврыг хүүхэд бүрээр хийлгэх ялангуяа хайчлах, наах, дүрс бүтээх, будах, ном бүтээх, жижиг булчин хөгжүүлэх дасгалууд, баримал хийх даалгавруудыг хийлгэхдээ багш өөрөө үлгэрлэн үзүүлэх, дагуулж хийлгэх зэргээр аль болох хүүхдээр даалгаврыг бүрэн гүйцэтгүүлэхэд нь анхаарах

Дүгнэх үе шатанд анги бүр бэлтгэл хөтөлбөрийн агуулгаар хүүхдийн эзэмшсэн чадвар, дадлыг үнэлж дүгнэсэн тайлант ангийн арга хэмжээ зохион байгуулсан. Энэ үеэр хүүхдүүдээр сурсан дуу, шүлэг, зүйр цэцэн үг уншуулах, эзэмшсэн чадварыг нь шалгах тест ажиллуулах (зургийг гүйцээн зурах г.м), тайлбартай дасгал хийлгэх зэргээр хөтөлбөрийн үр дүнг хүүхдийн гүйцэтгэлээр дүгнэсэн.



ҮР ДҮН

Нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлснээр хүүхдийн сурах суурь чадваруудад ахиц гарсан. Тухайлбал бэлтгэл хөтөлбөрийн дасгал ажлын дэвтрийн дасгал даалгаврын гүйцэтгэл 83,7%-ийн үзүүлэлттэй гарсан. Түүнчлэн бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр багш нарын заах аргын нэгдлээс сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, идэвхтэй сургалтын аргагүйг нэвтрүүлж ажиллах, тогтмол уулзалт хийж үр дүнгээ ярилцах, залуу багш нарт тусгайлан зөвлөгөө өгөх, харилцан арга туршлагаа солилцох зэрэг ажлуудыг төлөвлөгөөтэй зохион байгуулсан. Ингэснээр бага ангийн багш нарын хөтөлбөр төлөвлөлт, сургалтыг хөтлөн явуулах аргазүйн чадвар дээшилсэн.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бага ангийн багш нарын заах аргын нэгдэл, секц тодорхой туршлага хуримтлуулж цаашид эдгээр ажлуудаа жил бүр хэрэгжүүлэх чадавхтай болсон.

85-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Эргүүлдэг үеийн хүрд



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Баянзүрх дүүргийн 85 дугаар
бүрэн дунд сургууль



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Нэгдүгээр ангийн багш нар

ЗОРИЛГО

Тоглоомын арга ашиглан хүүхдийн үгийн нөөцийг нэмэгдүүлэх, унших чадварыг сайжруулах



АРГАЗҮЙ

Хүүхэд суралцахуйн ачаалал даахгүйгээс хичээлдээ дургүй болох, сурлагын хоцрогдол үүсэх шалтгаан болдог. Иймээс энэхүү бэрхшээлийг арилгах, хүүхдийн үгийн нөөцийг нэмэгдүүлэх, унших чадварыг сайжруулах зорилгоор монгол хэлний хичээлээр хүүхэд тоглох явцдаа суралцах боломжтой “**Эргүүлдэг үеийн хүрд**”-ийг эцэг эхийн дэмжлэг оролцоотойгоор хийлгэн сургалтад ашигласан юм. Эцэг эхчүүд энэ хүрдийг гэртээ хүүхэдтэйгээ хамтран хийж, гэр бүлийн орчинд хүүхдийнхээ сурах чадварыг дэмжихэд үр дүнтэй.

Эргүүлдэг үеийн хүрдийг хийхдээ эгшиг болон I шатны гийгүүлэгч, II шатны гийгүүлэгч гэсэн ангиллаар хийсэн. Ангийн хүрдийг хүүхэд дуртай үедээ хэрэглэх боломжоор ханган ангийн тавиурт хүүхдийн нурууны хэмжээнд тааруулан байрлуулан ашиглана. Сурагчид эргүүлдэг үеийн хүрдийг ашиглахдаа эгшигийг богино, урт, хосоор дуудан унших ба богино, урт, хос эгшигтэй үг олж хэлэх, нэрлэх зэргээр тоглох явцдаа эгшгээ нүдэлнэ. Мөн хүүхэд шат шатны гийгүүлэгч үзэх явцдаа бие биедээ зохиосон үе, үгээ уншуулах ба утгыг нь таалгах, ярилцах зэргээр бүтээлчээр уншиж, бичих боломжтой. Энэ явцдаа хүүхдүүд хосоороо болон багаар ажиллаж сурахад суралцдаг.

Ангийн багш, эцэг эхийн зөвлөлтэй хамтран сурагчдын гэрээр очих явцдаа үеийн хүрдээ хэрхэн ашиглаж байгаа, гэр бүлээрээ тоглосноор хүүхдэд ямар ахиц, өөрчлөлт гарч буй талаар ярилцаж, хүүхдэдээ цаг гарган ажиллаж байгаа эцэг эхийг урмын үгээр урамшуулдаг.

Эргүүлдэг үеийн хүрдийг хийхэд цаасан хайрцаг, тосон харандаа, усан будаг, хайч, өнгийн цаас, цавуу орох ба жижгээр хийхэд дэвтрийн хавтас ашигласан. Ийнхүү их зардал гаргахгүйгээр хүүхдээ уншуулж бичүүлж сургаж байгаадаа баяртай байгаа талаар эцэг эхчүүд талархан хэлдэг.



ҮР ДҮН

Эргүүлдэг үеийн хүрдийг хийж сургалтад ашигласнаар дараах үр дүнд хүрсэн. Үүнд:

- Сурагчид өөрсдөө үе, үг бүтээн нүдэлж, үг унших, зөв бичихэд суралцан, үгийн нөөц нь нэмэгдсэн. Мөн битүү, задгай үе бүтээх, нэг үетэй үг бүтээн уншсанаар сурагчдын унших хурд, чадвар сайжирсан.
- Хүүхдүүд хосоороо болон багаараа ажиллаж бүтээсэн үгийнхээ утгыг бусаддаа тайлбарлан ярьснаар өөртөө итгэлтэй болж бусадтай харилцах, өөрийгөө илэрхийлэх чадвар сайжирсан.
- Хүүхэд эцэг эхийнхээ хийсэн бүтээлээр бахархаж улам сайн сурах хүсэл тэмүүлэлтэй болсон.
- Эцэг эхчүүдийн хувьд багаар хамтран ажиллаж, бие биеэсээ суралцаж, хүүхдээ уншуулах, хүүхэдтэйгээ ажиллах арга барилд суралцсан.
- Сургуулийн эцэг эхийн өдөрлөг, тайлант уншлага, дүүргийн сайн туршлагын үйл ажиллагааны үзэсгэлэнд эргүүлдэг хүрдээ тавьж, олон нийтэд хүртээл болгосон ба сайн туршлагаар үнэлэгдсэн.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бага ангийн багш нарын заах аргын нэгдэл, секц тодорхой туршлага хуримтлуулж цаашид эдгээр ажлуудаа жил бүр хэрэгжүүлэх чадавхтай болсон.

79-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Багшийн хөгжлийг дэмжсэн мэргэжил дээшлүүлэх сургалтын сургуулийн тогтолцоог бий болгох



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Баянзүрх дүүргийн 79 дүгээр бүрэн дунд сургууль



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Бага ангийн сургалтын менежер

ЗОРИЛГО

Багшийн хөгжлийг дэмжсэн мэргэжил дээшлүүлэх сургалтын сургуулийн тогтолцоог бий болгох



АРГАЗҮЙ

Манай сургуулиас “Нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхыг бэхжүүлэх нь” төсөлд хамрагдахдаа “Багшийн хөгжлийг дэмжсэн” загвараар буюу бага ангийн багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын сургуулийнхаа тогтолцоог бий болгох хэлбэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно. Энэ зорилтыг хангахын тулд дараах 5 үе шаттай бүтэц хэлбэрийг ашигласан.

Багшийн хөгжлийг дэмжсэн мэргэжил дээшлүүлэх сургалтын сургуулийн тогтолцооны схем



1 Төслөөс зохион байгуулсан 5 бүлэг сургалтын модулиудын сургагч багш нарыг сайн бэлтгэх, сургалтын менежер сургагч багшийн сургалтуудад тогтмол идэвхтэй оролцох зорилт тавьсан. Үүний дараа үндсэн сургалтуудыг сургагч багш нарынхаа хүч оролцоотой сургууль дээрээ чанартай зохион байгуулсан ба сургалтад хамрагдсан багш нарын сургалтын ирц, оролцоо, идэвхийг тооцож ажлын үнэлгээний шалгуур болгож байсан.

2 Сургуулийн дотоод сургалтуудыг зохион байгуулахдаа төслөөс өгсөн заавар удирдамжийг мөрдөхийн зэрэгцээ сургуулийн удирдлага, сургалтын менежерийн зүгээс санаачлан ажлаа хэлэлцэх сургуулийн “дотоод цаг” гаргах, багш нар заах аргын нэгдэл, секцээрээ бүлгийн уулзалтууд хийх замаар сургалтын үеэр эзэмшсэн мэдлэг, ур чадвар, практик аргазүйг сургалтын үйл ажиллагаа, өөрийн эрхэлж буй ажилдаа хэрхэн тусгаж хэрэгжүүлэх талаар зөвлөн ярилцах боломж олгож байсан. Энэ үеэр сургагч багш нар, сургалтын менежер сургалтын агуулга, аргазүйн талаар зөвлөн туслах ажил зохион байгуулсан. Мөн дотоод сургалтуудын үеэр ЗАН төлөвлөгөө, удирдамж, сургалтын материал зэрэг багш ажилдаа хэрэглэх зүйлсийг боловсруулж гаргасан.

3 Төслийн хүрээнд зохион байгуулсан үндсэн болон дотоод сургалтын мөрөөр багш нар сурсан зүйлээ хийж хэрэгжүүлэх бүтээлч үйл ажиллагаа зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд багш нар хувиараа болон секц нэгдлээрээ сурсан зүйлээ хэрэгжүүлэх бүтээлч санаа цуглуулах, хийх ажлын төлөвлөгөөгөө бүлгийн хэлэлцүүлгээр ярилцах, харилцан туршлага судлах, залуу багш нартаа зөвлөн туслах, багш нарын дунд уралдаан тэмцээн зохион байгуулах зэрэг олон хэлбэрийн ажлууд хийсэн.



Сургуулийн дотоод сургалт

Жишээлбэл: Багш нарын дунд “Хүүхдийн хувийн мэдээлэл цуглуулах, ашиглах аргагүй” модуль сургалтаар эзэмшсэн аргагүйгээр ангийнхаа хүүхдүүдээс мэдээлэл цуглуулах туршлагаас хуваалцах уулзалт хийсэн. Багшийн компьютерийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор бүх багш нарын дунд “word” програм дээр түргэн бичилтийн уралдаан зохион байгуулсан. Үүний үр дүнд багш нарын компьютер дээр бичих, материал боловсруулах, хүүхдийн мэдээлэл өгөгдөл оруулж дүн шинжилгээ хийх ур чадвар мэдэгдэхүйц сайжирсан.

4 Манай сургууль бага ангийн багш бүр тухайн жилдхэрэгжүүлэхүйлажиллагааны төлөвлөгөөг боловсруулж сургалтын менежерээр батлуулан мөрддөг. Үйл ажиллагааны төлөвлөгөөг “Багшийн ажлыг үнэлэх журам”-ын дагуу хүүхдийн хөгжил төлөвшилд гарсан ахиц, авьяас чадвар, боловсролын үйлчилгээний хүртээмж, эрүүл мэнд гэсэн бүлэг үзүүлэлтүүдээр гаргах ба бүлэг тус бүрт багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын мөрөөр эзэмшсэн аргагүйг хэрэгжүүлэх ажлыг багтаадаг. Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгээр багш болон секцээрээ хичээлийн жилийн эцэст тайлан тавьдаг ба сургуулийн аварга багш, тэргүүний заах аргын нэгдэл жил бүр шалгаруулж урамшуулдаг.

5 Багшийг хөгжүүлэх дээрх сургалт, арга хэмжээний үр дүнд хүүхдийн сурлагын амжилт, ахицад өөрчлөлт гарсан байна. Тухайлбал монгол хэл, математикийн хичээлээр чадварт суурилсан шалгалтын харьцуулсан үзүүлэлтээр бүх ангиудад ахиц гарсан, 1-р ангийн монгол хэлний хичээлээр 19%, математикийн хичээлээр 10%-иар тус тус ахиц гарсан байна.



ҮР ДҮН

Дээрх багшийн мэргэжил дээшлүүлэх системтэй сургалтын тогтолцоог сургуульдаа нэвтрүүлснээр багшийн хөгжил, ажилдаа хандах хандлагад дараах өөрчлөлт гарсан гэж үзэж байна.

- Багш нар сургалтын шинэ мэдээлэл, аргагүйг эзэмшсэнээр тэдний аргагүй, хүүхэд болон эцэг эхтэй ажиллах арга барил сайжирсан
- Багш нар сургалтын үеэр ажлын цагаа урьдчилан зөв төлөвлөж, ажлаа хуваарилдаг болсон
- Сургалтуудад тасралтгүй суухыг хичээдэг, мэдээллээс хоцрохгүйн тулд өөрсдийгөө дайчилдаг болсон
- Аливааг санаачлах, бие даан ажил гүйцэтгэх чадвар дээшилсэн.
- Багшийн сургалтын аргагүй сайжирснаар багш нарын ажлын туршлага болон бүтээлч ажиллагаа дээшилж дүүрэг, хотын хэмжээнд зохион байгуулсан ажилд оролцож амжилт болон туршлагаа хуваалцах болсон.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Сургуулиас багшийн хөгжилд анхаарах, тэдний мэргэжлийг дээшлүүлэх ажил тогтмол, системтэй болсноор энэ талаарх сургуулийн өөрийн туршлага, чадавх бий болсон.

Багшийн ажлын үр дүнг харгалзан нэмэгдэл цалин хөлс, урамшууллыг бодитой олгох боломжтой болсон.

79-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Анги даасан багш нар хүүхдийн хувийн мэдээллийг үр дүнтэй ашиглах



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Баянзүрх дүүргийн 79 дүгээр бүрэн дунд сургууль



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Бага ангийн багш нар

ЗОРИЛГО

Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж хүүхдийн хичээл болон хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагаанд ашиглах



АРГАЗҮЙ

Төслийн хүрээнд “Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах аргазүй” модулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бага ангийн нийт багш нар хүүхэд бүрийн мэдээлэл цуглуулдаг. Цуглуулсан мэдээллээ дараах зорилгоор ашигладаг. Үүнд:

- 1 Хүүхдийн хөгжил ахицын талаарх анги даасан багшийн мэдээллийн сан бий болгох
- 2 Хүүхдийн хөгжил ахицын талаарх мэдээлэл дээр тулгуурлан хичээл, хүмүүжлийн ажлаа төлөвлөх
- 3 Эцэг эхчүүдийн хурал, уулзалтад хувь хүүхдийн талаарх мэдээллийг танилцуулах
- 4 Сурагчийн талаарх тодорхойлолт, баримт бичигт тусгах мэдээлэл бүрдүүлэхэд ашиглах
- 5 Цэцэрлэг сургуулийн багш нар мэдээлэл солилцох, хамтран ажиллах

Дээрх чиглэлээр хийсэн ажлын 2 туршлагаасаа танилцуулъя.

1. Нэгдүгээр ангийн болон бусад ангийн бага ангийн багш нар мэдээлэл цуглуулах аргазүйн дагуу даасан ангийнхаа хүүхдүүдийн ерөнхий болон эрүүл мэнд, хөгжил чадварын талаарх мэдээлэл цуглуулдаг. Цуглуулсан цахим мэдээллийн үр дүнд тулгуурлан хүүхдийн мэдлэг, чадвар, дадлын түвшинд дүн шинжилгээ хийж хөгжлийн хавтас бүрдүүлдэг. Түүнчлэн багш зөвхөн цуглуулсан мэдээллээр хязгаарлалгүй



Багш Т.Болорцэцэгийн ангийн хүүхдүүдийн хөгжлийн судалгааны хавтас

Хамтран суралцах чадварын шалгуур						
№	Өөрийнөө илэрхийлэх чадварын шалгуур	Хамтран сайн явснаа хэлж чаддаг	Өөрийнхөө үзэл мөхлөг хэлдэг	Өгнөх зөв дүгээр	Амжилттай төлөөлөгчдийг сонгох	Тайлбар
1	Өөрийн санаа бодлоо бүтэн гүйцэтгэхээр эргэлтэдэг	25	18	2	Амжилттай төлөөлөгчдийг сонгох	40-45 минуттай
2	Утасны харилцааг утасны өнгөтэй бусад харилцаа	21	7			
3	Бусдын хэргийг хүндэтгэн, тэдэнд туслах сонголт	28				
4	Гэрээг гэрээлэхэд зөв зөвлөхгүй байдаг	23				
5	Самуунд зурхайгаа тунгай асуулт тавих харилцааг хүндэтгэн	20	8	1	Хамтран	Хүндэтгэн
6	Өөрийн үйлдэл, сонирхолд үйлдэл тусгай байдаг	22	3			
7	Өөрийн сонирхолд чөлөөтэй хариулдаг	23	6			
8	Насны хөгжлийн харилцааг үзсэн хөгжлийн (Жишээ нь - Та хэдэн өдөр хэдэн өдөр хэдэн өдөр) Өгнөх зөв дүгээр (7-р багш)	21	2	2	Амжилттай төлөөлөгчдийг сонгох	40-45 минуттай
Нийт		209	48	8		




нэмэлт судалгаа авч мэдээллээ баяжуулдаг. Жишээлбэл: хүүхдийн сонирхдог зүйлсийн талаар, хувийн авьяас, чадвар, хамрагддаг секц, дугуйлан, бусад гэр бүлийн гишүүд гэх мэт. Мөн нэгдүгээр анги даасан багшаас гадна ангийн багш нар мэдээлэл цуглуулах асуулгыг өөрийн ангийн хүүхдийн

нас, сэтгэхүйн түвшинд нийцүүлэн өөрчилж судалгааг тогтмол авдаг болсон. Жишээлбэл: 4-р ангийн хүүхдэд зориулан “Хамтран суралцах чадвар”-ын бүлэг үзүүлэлтийн асуулгыг “Өөрийн санаа бодлоо бүтэн гүйцэтгэхээр илэрхийлэх”, “Уншсан үлгэрийнхээ утгыг ойлгон бусаддаа ярих”, “Гэрээсээ сургуульд ирэх замаа тайлбарлах” гэх мэтээр чадварын түвшинг ахиулан асуулгыг боловсруулж ашигласан. Энэ мэтээр анги даасан багш нар хүүхдийн хөгжлийн хавтас, мэдээллийн сантай болж байна.

Манай сургуулийн багш нар хүүхдийн хөгжлийн судалгааны мэдээллийг хичээл хүмүүжлийн ажлаа төлөвлөж явуулахад тусган ажиллаж байна. Жишээлбэл: 2-р ангийн 8 багш даасан ангийнхаа хүүхдийн гарын жижиг булчингийн хөгжлийн талаар мэдээлэл цуглуулсан. Энэхүү мэдээлэлдээ багш нар дүн шинжилгээ хийж үзэхэд “шагай няслах найдгайгаар наадах”, “зурлага шугам давуулалгүй бичих” үзүүлэлтээр сурагчид доогуур үзүүлэлт авсан юм. Иймд 2-р ангийн ЗАН-ийн багш нар зөвлөлдөөд тухайн хичээлийн жилд шагайн наадгайн төрлийн уралдаан тэмцээнийг хичээлээс гадуурх ажлын төлөвлөгөөндөө түлхүү тусгахаар шийдэж ажилласан. Жишээлбэл: “Дээлтэй Монгол” өдөрлөгөөр морь уралдуулах тэмцээнийг анги бүр зохиосон, ангидаа шагайгаар наадах, тоглоомын орчин бүрдүүлэх зэргээр ажилласан.


№	анги	бүлэг	сурагчдын тоо	Үзэг харандааг зөв бариад, зурж бичдэг	Шагай няслах наадгайг наадаг	Зурлагыг дэвтрийн шугамд баримжаалан нямбай бичдэг	Зургийг өнгийн харандаа, фломастраар зураас давуулахгүй буддаг	Цаасыг дугуй дөрвөлжин, гурвалжин хэлбэр дүрс гарган хайчилдаг	Хайчилсан дүрсээ цавуудаж наадаг	Хувцасны товчоо зөв товчилж тайлдаг	Гутлын үдээсээ үддэг, үдээс үдэх тоглоом тоглодог	Том, жижиг шүр, товчийг утсанд хэлхдэг	Эвлүүлдэг зөв эвлүүлдэг /puzzle/
				1	2	3	4	5	6	7	8	9	10
1	2	а	34	30	18	20	27	20	20	34	34	30	30
2	2	б	33	31	22	25	25	25	25	33	33	33	28
3	2	в	33	32	16	22	23	22	22	30	30	33	25
4	2	г	34	28	14	15	18	20	20	27	29	28	20
5	2	д	33	30	20	20	33	26	26	30	30	33	30
6	2	е	33	31	15	24	28	30	30	27	27	20	15
7	2	ё	33	29	18	17	20	20	20	30	30	28	20
8	2	ж	30	26	13	12	15	18	18	26	28	30	28
нийт			263	237	136	155	199	181	181	237	241	235	196

Жижиг булчингийн хөгжлийн судалгааны нэгтгэл:



Өөрийгөө илэрхийлэх чадварын бүлэг үзүүлэлтээр 2-р ангийн хүүхдүүд “уншиж, ярьсан үлгэрийн утгыг ойлгон бусаддаа ярих “ гэсэн чадварын үзүүлэлтээр доогуур үнэлгээ (51%) авсан тул багш бүр даасан ангидаа хичээлийн үеэр “Үлгэр унших цаг” гаргаж тогтмол явуулдаг болсон. Мөн сургуулиас “Үлгэр амилах цаг” наадам зохион байгуулсан бөгөөд эхний байрыг энэ ангийн хүүхдүүд эзэлсэн.

“Өөрийгөө илэрхийлэх чадвар”-н судалгааны нэгтгэл



ҮР ДҮН

Бага ангийн багш нар хүүхдийн хувийн мэдээлэл цуглуулж ашигладаг болсноор хүүхдийн хөгжлийн ахицад дүн шинжилгээ хийх чадвартай болж, улмаар энэхүү мэдээллээ дээрх 5 чиглэлээр хичээл хүмүүжлийн ажилдаа тусган хэрэгжүүлдэг болсон. Багш нар хүүхдийн хөгжлийн мэдээллийн хавтас тогтмол бүрдүүлж ашигладаг болсноор хүүхдийг хөгжүүлэх хичээл хүмүүжлийн ажлыг цуглуулсан мэдээлэлдээ үндэслэн төлөвлөж хэрэгжүүлэх чадварт суралцсан.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Сургуулийн зүгээс дээрх ажлуудыг багшийн ажлыг үнэлэх нэгэн шалгуур болгон жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөнд нь тусган биелэлтийг тухай бүр үнэлж, цалин урамшуулалтай холбон дүгнэдэг болсон.

65-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Хамран сургах тойргийнхоо цэцэрлэгтэй хамтран сургууль-цэцэрлэгийн залгамж холбоог хангаж ажиллах чиглэлээр хэрэгжүүлсэн туршлага



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Чингэлтэй дүүргийн
37 дугаар бүрэн дунд сургууль



ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Цэцэрлэг, сургуулийн багш нар

ЗОРИЛГО

Сургууль-цэцэрлэгийн залгамж холбоог үр дүнтэй хангаж ажиллах



АРГАЗҮЙ

Тус сургууль хамран сургах тойргийнхоо 103 дугаар цэцэрлэгтэй хамтран сургууль-цэцэрлэгийн залгамж холбоог ханган ажиллах туршлага хуримтлууллаа. Төслийн багаас өгсөн удирдамж, аргазүйн дагуу 37 дугаар сургуулиас дараах чиглэлийн ажлуудыг тусгасан ажлын төлөвлөгөөг боловсруулж, захирал, эрхлэгчийн шийдвэрээр баталгаажуулж мөрддөг.

Энэхүү төлөвлөгөөнд сургалтын агуулга, аргазүйн залгамжийг хангах зорилгоор сургууль, цэцэрлэгийн багш нарын хамтарсан уулзалт зохион байгуулах, цэцэрлэгээс сургуульд элсэн орох хүүхдийн хувийн мэдээллийг бүрдүүлж, нэгдүгээр ангийн багш нарт хүлээлгэн өгөх, бэлтгэл бүлгийн хүүхдүүдийг сургуультай танилцуулах аялал хийх, сургуульд бэлэн байдлын талаарх хөгжлийн үзүүлэлтийг бэлтгэж өгөх зэрэг төрөл бүрийн ажлууд төлөвлөн явуулдаг.

Эдгээрээс онцлох туршлага бол цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн багш нар хүүхэд нэг бүрээр дараах мэдээллийг агуулсан хүүхдийн хөгжлийн хавтас бүрдүүлэн нэгдүгээр ангийн багш нарт жил бүрийн хавар 5-р сард хүлээлгэн өгч хэвшсэн ажил юм.

Дээрх төлөвлөгөөний хүрээнд цэцэрлэг, сургуулийн багш нар харилцан танилцах айлчлал, сургалтыг тус тусын байгууллага дээр зохион байгууллаа. Цэцэрлэг дээр зохион байгуулсан сургалтын явцад 37 дугаар сургуулийн багш нартаа

ЦЭЦЭРЛЭГИЙН БЭЛТГЭЛ БҮЛЭГ

Хүүхдийн хувийн хөгжлийн мэдээлэл хавтас:

- Хүүхдийн танилцуулга
- Хөгжлийн мэдээлэл
 - Бие бялдрын өсөлт хөгжил, эрүүл мэнд
 - Оюун ухаан
 - Нийгэмшихүй
 - Хувийн онцлог
- Фото зураг
- Миний амжилт
- Миний Бүтээл /миний бичсэн зүйлс, зурсан зураг/
- Эцэг эхийн оролцоо



СУРГУУЛИЙН НЭГДҮГЭЭР АНГИ

Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулах хавтас:

- Хүүхдийн хувийн дэлгэрэнгүй мэдээлэл
- Хүүхдийн эрүүл мэндийн мэдээлэл
- Хүүхдийн хөгжил чадварын талаарх мэдээлэл
- Сурагчийн хөгжил, чадварын ахицын мэдээлэл

цэцэрлэгийн анги бүлгийн орчин, хүүхдийн сургалт хүмүүжлийн үйл явцтай танилцуулснаас гадна багш бүр цэцэрлэгийн цөм хөтөлбөрийн агуулгын хөдөлгөөн-эрүүл мэнд, байгаль-нийгмийн орчин, хэл яриа, математик гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдээр хүүхдэд эзэмшүүлэх чадвар, дадал, сургалтын аргазүйн онцлогийн талаар хичээл заасан. Сургуулийн зүгээс сургууль, анги танхимын орчинтой танилцуулахаас гадна нэгдүгээр ангийн хүүхдийн сургалтын хөтөлбөр, аргазүйтэй танилцуулах, хүүхдийн хөгжлийн хувийн мэдээллийг цуглуулах аргазүйн чиглэлээр сургалт явуулсан.

Цэцэрлэгийн сургалттай танилцах үеэр хүүхдийн дунд явуулдаг сэдэвт хичээл хүмүүжлийн ажлууд, тоглоомын аргазүй, хүүхдийн гарын жижиг булчин хөгжүүлэх үйл ажиллагаатай танилцаж нэгдүгээр ангийн багш нарын сургалтад авч ашигласан.



ҮР ДҮН

Хамран сургах тойргийнхоо цэцэрлэгтэй хамтран ажилласнаар 6 настай хүүхдүүд сургуульд элсэн суралцах үедээ сургуулийн орчинд дасан зохицох үйл явц нь илүү түргэн явагддаг болох нь ажиглагдсан. Жишээлбэл: Энэхүү төсөлд хамрагдахаас өмнө манай сургуулийн нэгдүгээр ангийн бүлэг бүрээс ихэвчлэн 4-5 хүүхэд эхний долоо хоногтоо уйлах, анги руугаа орохгүй ээж ааваасаа салахгүй зууралдах, багшаасаа айх зэрэг сэтгэлзүйн сөрөг үзэгдлүүд гардаг байсан. Харин хүүхдийг цэцэрлэгийн бэлтгэл бүлэгт байх үеэс нь сургууль, анги, багш, найз нөхдийнх нь хамтаар сургуулиар аялуулах, нэгдүгээр ангийн багш нарыг өмнөх шатны боловсролын байгууллагын сургалтын онцлог аргазүйтэй танилцуулах зэрэг арга хэмжээг сургууль цэцэрлэг хамтран зохион байгуулснаар хүүхдэд тохиолдох сэтгэлзүйн сөрөг үзэгдлүүд багасч улмаар сургуульдаа хурдан дасан зохицож, хүүхдүүдийн суралцах чадвар ахиж байлаа.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Сургууль-цэцэрлэгийн залгамж холбоог хангах чиглэлээр цэцэрлэгтэй хамтран ажиллах үйл ажиллагааг сургуулиуд жил бүрийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх нь зүйтэй.

67-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах аргазүй



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Сонгинохайрхан дүүргийн 67 дугаар бүрэн дунд сургууль



ХАРИУЦАХ АЖИЛТАН

1-5 ангийн багш нар

ЗОРИЛГО

“Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах аргазүй” модулийн аргазүйг сургуулийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэн сурагчийн хувийн хэргийг хөтлөхөд ашиглах



АРГАЗҮЙ

6 настай сурагчдыг сургуульд хүлээн авахад суралцагч бүрийн хөгжил, чадварын төвшин харилцан адилгүй байдаг ба тэдгээрийг багш сурагч бүрийг судлах шаардлага гардаг. Бага ангийн багш нар хүүхдийн хөгжил, чадварын судалгааг анги бүрийн хүүхдийн насны онцлогт тохируулан шалгуур үзүүлэлтийг боловсруулж, хичээлийн жилийн эхэнд болон төгсгөлд 2 удаа судалгааг авч мэдээлэл цуглуулдаг. Мөн “360 хэмийн тархалтын хүснэгт”-ийг хөтөлж, цуглуулсан мэдээллийг сурагчийн хувийн хэрэгт “сурагчийн хөгжил, төлөвшлийн тодорхойлолт”-ыг бичихдээ ашиглаж байна. Үүнд:

- 1 **Сурагчийн мэдлэг чадварын өөрчлөлт, түүний шалтгаан хэсэгт:** Сурагчийн хөгжил төлөвшлийг үнэлэхдээ тухайн сурагчийн нас, сэтгэхүйд тохирсон хэл, нийгэм, танин мэдэхүйн чадварын шалгуураар хөгжлийн ахицыг тогтоож, энэ мэдээлэл дээр тулгуурлан сурагчийн ололт амжилт болон цаашид анхаарах асуудлын талаар бичдэг.
- 2 **Хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагаанд оролцсон байдал, түүний үр дүн хэсэгт:** Сурагчийн амьдрах ухааны чадварын ахицын үзүүлэлт судалгааны дүнг мэдээлэл болгон ашигладаг.
- 3 **Эрүүл мэндийн байдал хэсэгт:** Эцэг эх, сургуулийн эмч, өрхийн эмчээс авсан мэдээлэл, судалгаанаас үндэслэн суралцах чадварт хамаарах эрүүл мэндийн зөвлөгөөг оруулдаг.
- 4 **Анхаарах зүйл хэсэгт:** “360 хэмийн тархалтын хүснэгт”-ээс сурагчийн сурах хөгжих, төлөвших чадварт сөргөөр нөлөөлж буй асуудлын талаар сурган хүмүүжүүлэх зөвлөгөөг тус тус оруулж байна.

СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖИЛ, ТӨЛӨВШЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Анги 1 Бүлэг 5 2018 он 05 сар 16 өдөр

№	Чиглэл	Бөгшөөх үндэслэл
1	Сурагчид чин мэдлэг, чадварын өөрчлөлт, түүний шалтгаан	Сурагч орж барих сайн байсан. Өвчтөнийг сайн эмчлэх бичиг баруун гарын
2	Хичээлээс гадуух сургалтын үйл ажиллагаанд оролцсон байдал, түүний үр дүн	Хичээлээс гадуух зохиогдох бичиг сайн баруун гарын үр дүн үзвэл зөв байсан нь үзүүлжээ
3	Сурагчид чин ололт, амжилт	Ололт амжилт гаруулах бичиг баруун гарын үр дүн үзвэл амжилт
4	Эрүүл мэндийн байдал	Эрүүл мэнд сайн байсан. Өвчтөнийг сайн эмчлэх бичиг баруун гарын
5	Анхарах асуудал	

Анги удирдсан багш: *А.Оршимаа* (сарны эсрэг) *Н.Оршимаа* (нар)

Сурагчийн мөнхжир (хөдөө): *Н.Оршимаа* (сарны эсрэг) *Н.Оршимаа* (нар)

Эцэг, эх, эсрэг хамгаалагч: *Ш.Оршимаа* (сарны эсрэг) *А.Оршимаа* (нар)

СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖИЛ, ТӨЛӨВШЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Анги 1 Бүлэг 5 2018 он 06 сар 06 өдөр

№	Чиглэл	Бөгшөөх үндэслэл
1	Сурагчид чин мэдлэг, чадварын өөрчлөлт, түүний шалтгаан	Талын туршид зөвхөн 1-2 удаагийн үйлдэл үзүүлжээ. 20 туршид талын туршид бүхний туршид сайн үзүүлжээ. Голлоо баруун гарын үр дүн үзвэл амжилт гаруулах бичиг баруун гарын үр дүн үзвэл амжилт
2	Хичээлээс гадуух сургалтын үйл ажиллагаанд оролцсон байдал, түүний үр дүн	Ололт амжилт гаруулах бичиг баруун гарын үр дүн үзвэл амжилт гаруулах бичиг баруун гарын үр дүн үзвэл амжилт
3	Сурагчид чин ололт, амжилт	Ололт амжилт гаруулах бичиг баруун гарын үр дүн үзвэл амжилт гаруулах бичиг баруун гарын үр дүн үзвэл амжилт
4	Эрүүл мэндийн байдал	Ололт амжилт гаруулах бичиг баруун гарын үр дүн үзвэл амжилт гаруулах бичиг баруун гарын үр дүн үзвэл амжилт
5	Анхарах асуудал	Эрүүл мэндийн үйлдэл үзүүлжээ. 20 туршид талын туршид бүхний туршид сайн үзүүлжээ. Голлоо баруун гарын үр дүн үзвэл амжилт гаруулах бичиг баруун гарын үр дүн үзвэл амжилт

Анги удирдсан багш: *Н.Оршимаа* (сарны эсрэг) *Н.Оршимаа* (нар)

Сурагчийн мөнхжир (хөдөө): *Н.Оршимаа* (сарны эсрэг) *Н.Оршимаа* (нар)

Эцэг, эх, эсрэг хамгаалагч: *Ш.Оршимаа* (сарны эсрэг) *А.Оршимаа* (нар)

“360 хэмийн тархалтын хүснэгт”-ийг ашиглахаас өмнөх болон ашигласны дараах тодорхойлолт

✓ ҮР ДҮН

- 1 “360 хэмийн тархалтын хүснэгт”-ийг ашигласнаар өмнө сурагчийн хувийн хэрэгт бичдэг байсан нийтлэг хэвшмэл тодорхойлолттой харьцуулбал илүү тодорхой, дэлгэрэнгүй, ажиглалт судалгаанд суурилсан, зөвхөн тухайн сурагчийн онцлогийг бодитоор тодорхойлдог дэвшил гарсан. Ингэснээр багш нь сурагчаа, эцэг эх нь хүүхдээ зөв үнэлэх боломжтой болж байна.
- 2 Анги удирдсан багш сурагчийн талаарх хувийн мэдээллийг эцэг эх, асран хамгаалагч, өрхийн эмч, мэргэжлийн багш нараас цуглуулж, энэхүү мэдээллээ компьютерийн хэрэглээний Excel программд оруулан ахицын судалгаа хийж ажилласнаар багш нарын мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх чадвар сайжирч байна.
- 3 Нэгдүгээр ангид элсэн орж буй хүүхдийн хөгжил чадварын талаарх мэдээллийг эцэг эх, цэцэрлэгийн багш нараас авч ашигласан нь багш сурагчдынхаа талаар бодитой мэдээлэлтэй болж, тэдний сургуульд дасан зохицох, суралцах чадварт эергээр нөлөөлсөн.
- 4 Ангийн багш цуглуулсан мэдээлэлдээ дүн шинжилгээ хийснээр сурагчийн онцлогийг мэддэг болж, улмаар хүүхэд бүрт тулгарч болох бэрхшээлийг урьдчилан тооцож чаддаг болсон.
- 5 Багш хичээлийн төлөвлөлт хийхдээ сурагчдынхаа ялгаатай байдалд тохируулан аргазүйгээ боловсруулж байна.

△ О.О ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

“Хүүхдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглах аргазүй” модулийг багш нар ашиглан хэрэгжүүлэх чадавхтай боллоо. Энэ туршлагадаа тулгуурлан шинэ багш нартаа аргазүйн дэмжлэг үзүүлэх хэлбэрээр бага ангийн багш нар бүгд жил бүр хэрэгжүүлж явах бүрэн боломжтой.

17-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Бага, дунд, ахлах ангийн багш нарын хамтын ажиллагааг дэмжих замаар “Нэгдүгээр ангийн багш нарт сургалтын хэрэглэгдэхүүн хийж туслах аян”



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Чингэлтэй дүүргийн 17 дугаар бүрэн дунд сургууль



ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Нэгдүгээр анги даасан багш нар

ЗОРИЛГО


Нэгдүгээр ангийн багш нарын ажлын ачааллыг бууруулах, хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагаагаа зохион байгуулахад нь тэдэнд туслалцаа үзүүлэх зорилгоор тус сургуулийн бусад багш нар гарын доорх материал ашиглан сургалтын хэрэглэгдэхүүн, тараах материал бэлтгэх



АРГАЗҮЙ

Энэхүү аяны хүрээнд 2 үе шаттай арга хэмжээг зохион байгуулсан. **Эхний үе шатанд** манай сургуулийн дунд, ахлах ангийн буюу мэргэжлийн багш нар мэргэжлийн заах аргын нэгдлээрээ (монгол хэл, математик г.м) хамтран нэгдүгээр ангийн багш нарт зориулан гарын доорх материалууд ашиглан сургалтын хэрэглэгдэхүүн хийж өгдөг. Жишээлбэл: Байгалийн ухааны хичээлийн ЗАН-ээс эрхлэн “Дөрвөн улирал”-ын онцлог харуулсан багц хэрэглэгдэхүүн, монгол хэлний хичээлийн ЗАН-ээс хүүхдийн унших зохиолын эх 20 ш, үлгэр 30ш, битүү задгай үеийн зурагт үзүүлэн, гадаад хэлний хичээлийн ЗАН дуудлага ижил үсгийн ялгааг таниулах үзүүлэн, математик, мэдээлэл зүйн багш нар тоо тооллын 2, тооны бүтэц харуулсан 10, хөдөлгөөнт үзүүлэн 25ш, БАЗАН даалгаврын сан, зурагт тоглоом, хөдөлгөөнт тоглоом, том жижиг ном гэх мэтээр тус тус хийж сургалтын хэрэгцээнд нийлүүлсэн.





Бусад багш нарын ЗАН-ээс хийж нийлүүлсэн сургалтын хэрэглэгдэхүүн

Аяны дараагийн үе шатанд дээрх хийж өгсөн сургалтын хэрэглэгдэхүүнд түшиглэн бусад мэргэжлийн багш нар нэгдүгээр ангийнханд хичээл заан, тэдний дунд хичээлээс гадуурх сонирхолтой ажлууд зохион байгуулдаг. Жишээлбэл: Нэгдүгээр ангийн “Үлгэрийн цаг”- арга хэмжээгээр бусад хичээлийн заах аргын нэгдэл бүр урьдчилан гаргасан хуваарийн дагуу сурагчдын сонсох, ярих чадварыг хөгжүүлэх зорилгоор нэгдүгээр ангийн сурагчдын дунд тэдний нас, сэтгэхүйд тохирсон үлгэр уншиж өгөх, үлгэрчилсэн дүрийн тоглолт үзүүлэх (зурагт үзүүлэн, хуруун хүүхэлдэй ашиглах г.м) арга хэмжээг зохион байгуулдаг. Энэ нь хүүхдүүдэд тун сонирхолтой, хөгжилтэй арга хэмжээ болсноос гадна бусад багш нартайгаа танилцах, сургуулийн орчин, хүмүүст дасан зохицоход эергээр нөлөөлж байсан.

Энэхүү аян нь сургуулийн хувьд шинэлэг үйл ажиллагаа байсан бөгөөд өмнө нь зөвхөн бага ангийн багш нарыг оролцуулдаг байсан бол дунд, ахлах ангийн багш нарыг татан оролцуулснаар багш нарын хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, бие биеэсээ суралцах боломж олгосон арга хэмжээ болсон.



ҮР ДҮН

Аяны хүрээнд нэгдүгээр ангийн багш нар хичээлийн болон хичээлийн бус цагийн үйл ажиллагаанд ашиглах хэрэглэгдэхүүний сантай болсон. Мөн бусад багш нарын сургалтын арга барилаас суралцах замаар сургалтын аргазүйгээ баяжуулсан үр дүнтэй байлаа.

Нэгдүгээр ангийн сурагчдын хувьд өөр өөр сэдвийн хүрээнд сонирхолтой хэлбэрээр хичээл заалгаснаар хичээлдээ улам бүр сонирхолтой болж, тэдний хичээлд оролцох идэвх сайжирсан. Тухайлбал, БАЗАН-ийн дөрвөн улирлын багц үзүүлэн нь Хүн орчин, Монгол хэлний хичээлийн агуулгыг интеграцчлан заахад дөхөм болж, сурагчдын үгийн баялгийг нэмэгдүүлэх, зохион ярих чадварыг дээшлүүлэхэд эергээр нөлөөлсөн. Мөн цаашид 2,3-р ангид хэрэглэх боломжтой үзүүлэн болж чадсан юм.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Багш нар уг үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог болсноор цаашид жил бүр тогтмол зохион байгуулах, зохион байгуулалтын арга барил, хэлбэрийг нь сайжруулан нэгдүгээр анги төдийгүй бага ангийнханд ашиглаж болохуйц хичээлийн хэрэглэгдэхүүнээ баяжуулаад явах бүрэн боломжтой. Сургуулийн захиргааны зүгээс багштай байгуулах хөдөлмөрийн гэрээнд энэ талаарх заалт оруулснаар уг ажлыг албажуулах, ажлын үр дүнтэй холбож тогтвортой явуулах бололцоо олгоно.

ТӨСӨЛД ХАМРАГДСАН СУРГУУЛИУД



САЙН ТУРШЛАГА

Нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн өөрийн үнэлгээний аргазүй



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Төслийн зорилтот бүх сургууль



ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Сургуулийн захирал, сургалтын менежер

ЗОРИЛГО

Сургууль нэгдүгээр ангийн сурагчдыг дэмжиж буй бүтэц, тогтолцоо, үйл ажиллагаагаа үнэлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянан засварлах, цаашдын зорилгоо тодорхойлох



АРГАЗҮЙ

Сургууль нь нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн бодлого, орчин, хүний нөөцийн чадавх, сургалтын үйл ажиллагаа, эцэг эхийн оролцоо болон орон нутгийн байгууллагатай хамтын ажиллагаа гэсэн 6 чиглэлээр өөрийн үнэлгээг хийж гарааны нөхцөл байдлаа тодорхойлодог.

Чиглэл тус бүр 1-5 хүртэлх түвшинтэй бөгөөд түвшинг тодорхойлох шалгууруудтай.

Төслийн зорилтот сургуулиуд энэхүү үнэлгээн дээр суурилсан “Дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр” боловсруулан ажиллаж байна. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд сургуулийн дүрэм, дотоод журам, багш ажилтнуудын хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, сургууль, ангийн дэг, хамтын ажиллагааны гэрээ зэргийг сайжруулан шинэчилж хамт олноороо хэлэлцэн баталгаажуулсан. Энэхүү эрхзүйн зохицуулалт, зохион байгуулсан арга хэмжээ нь сургуулийн нэгдүгээр ангийн сурагчдыг дэмжих чиглэлээр тодорхойлсон сургуулийн зорилго, бодлогыг хэрэгжүүлэх, цаашид тогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлэх гол үндэс болсон.

Сургуулийн нөхцөл байдлын үнэлгээг хичээлийн жилийн эцэст дахин хийж сургууль хүрсэн үр дүнгээ тодорхойлж дараагийн хичээлийн жилдээ “Дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлдэг.

СХД-ийн 65 ДУГААР СУРГУУЛИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ



104 дугаар сургуулийн ЯХИС-ий хамтран хэрэгжүүлж буй "Нагдугаар ангийн сурагчдын сурацдаг чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадварыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд 2017-2018 оны хичээлийн эгэлд хийж ажил хөтөлбөр

Наг. Сургуулийн бодлого				
№	Үйл ажиллагаа	Хариуцах өвч	Хугацаа	Нөөц
1	Хичээлийн ажил хөтөлбөрт тооцогдуулсан 1 ангийн сурагчдыг хүлээн авах	Сургалтын менежер, нийтийн ажилтан	IXY1	II ангийн багш, суралцагчид, I ангийн багш, эцэг ахчуд
2	I ангийн багш нарыг сургуулийн дотоод журмын, болшийн ахуйн байрны тусгаарлолт, мэргэжлийн гэрээнд зориулсан хараат өргөмжлөлийг танилцуулах	Сургуулийн зохиогч	IX сар	2007 оны 354 дугаар тушаалын хавсралт
3	Нагдугаар ангийн багш нарыг хөнгүүр байгууллага зурдаг ажилгаас чөлөөлөх	Сургалтын менежер	2017-2018 оны хичээлийн жил	
4	I ангийн эцэг ахын зөвлөлийн дарга төлөөлөгч сонгох, тасвины агуулгаа, үйл ажиллагааг танилцуулах, сургуулийн хөтөлбөрт оруулах санал өгөх.	Сургуулийн зохиогч	X сар	Ангиддын эцэг ахын зөвлөлийн дарга нараар санал дан сургуулийн эцэг ахын зөвлөлийн даргыг сонгоно.
Хойр. Сургуулийн өрчин				
5	Сургуулийн өрчин ам таварын асдд галтгаас рхэдийн сарилгах тэмдэг тэмдэглэл, хурд савруулалт, гэрээний таваруул	Сургуулийн зохиогч, нийтийн ажилтан	IXY20 сар	36 дугаар хорооны агадас, Зөвлөл шийдлийн тасга
6	I ангийн сурагчдад үзүүлэх "School roles" зрүүлэн хяналт дэмжихийг нэгжүүлэх	Нийтийн ажилтан	2017-2018 оны хичээлийн жил	Эцэг ахчуд

ХҮШ-ний багууд үнэлгээгээ дахин хийж, ололт, амжилтаа дүгнэлээ.

№	Агуулга 6 чиглэлээр	үнэлгээ			
		2016-10 сар	2017-02-09	ажигч	2017-09 сар
1	Сургуулийн бодлого	2.9	4	1.1	3.46
2	Сургуулийн орчин	3.4	4	0.6	3.8
3	Хүний нөөц	2.9	4.2	1.3	3.0
4	Сургалтын үйл ажиллагаа	2.7	3.8	1.1	3.8
5	Эцэг ахын оролцоо	2.6	4	1.4	3.32
6	Хамтын ажиллагаа	1	2	1	3.3
	мэтгэл	15.5	25.9	6.5	20.87
	оноо	2.58	4.3	1.08	3.44
	үнэлгээ	дунджаас доогуур	дунджаас дээгүүр	ажигч өргөсөн	дунджаас

Сонгинохайрхан дүүргийн 76-р сургууль



ҮР ДҮН

Сургууль нэгдүгээр ангийн сурагчдыг дэмжих чиглэлээр өөрсдийн давуу болон сул талыг тодорхойлсон. **“Дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр”** нь нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээнд суралцагчийг сургуульд хүлээн авах бэлтгэл үе шатаас эхлээд хичээлийн жилийн туршид сургуулийн нийт удирдах ажилтан, бусад ажилтнууд тодорхой үүрэг хариуцлагатайгаар оролцож, орон нутгийн байгууллага, сургуулийн эцэг эхийн зөвлөл, эцэг эхтэй хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Цаашид нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн бодлого хөтөлбөрийг улам боловсронгуй болгох, зохион байгуулах үйл ажиллагааг сургуулийн хичээлийн жилийн төлөвлөгөөний нэг хэсэг болгон төлөвлөх нь зүйтэй.

Сургуулийн өөрийн үнэлгээг тогтмол хийж үр дүнг үнэлж, засан сайжруулах, бий болгосон эрхзүйн зохицуулалт, хэрэгжүүлэх механизмыг жилийн болон хэтийн төлөвлөлт үйл ажиллагаандаа тусгана. Энэ үйл явцад оролцлогч талууд болох хамран сургах тойргийн байгууллагууд, эцэг эхийн төлөөллийг тогтмол оролцуулах нь үнэлгээг бодит болгох ач холбогдолтой.

ТӨСӨЛД ХАМРАГДСАН СУРГУУЛИУД



САЙН ТУРШЛАГА

Нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургуулийн засаглал



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Төслийн зорилтот бүх сургууль



ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Сургуулийн захирал, сургалтын менежер

ЗОРИЛГО

Сургууль нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжихэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх



АРГАЗҮЙ

Нэгдүгээр ангийн сурагчдын дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн зорилгыг хэрэгжүүлэхдээ “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр” боловсруулсан.

Сургуулийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эрхзүйн орчныг бүрдүүлэх, түүний зохицуулалтыг хийх зайлшгүй шаардлагатай байдаг. Үүнд:

- Сургуулийн дүрэм, дотоод журам, сургууль, ангийн дэгийг хянан сайжруулж, баталгаажуулж мөрдөх


Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих үйл ажиллагаанд сургуулийн бүх ажилтнууд, орон нутгийн байгууллагуудыг ажил үүргийн дагуу оролцуулах нь зүйтэй. Тэдний оролцоо, үүрэг хариуцлагыг хөдөлмөрийн гэрээ, дотоод журам, ажлын байрны тодорхойлолт зэрэг эрхзүйн баримт бичигт тусгаж өгсөн. Эдгээрийг хийхдээ “Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих сургуулийн хөтөлбөр” модулийн 2 дугаар бүлэг дэх аргачлалыг ашигласан. Жишээлбэл: Сургууль бүрийн өөрийн онцлог, боломж, давуу болон сул тал, засаглал, санхүүгийн нөөц харилцан адилгүй учраас дараах байдлаар эрхзүйн өөрчлөлтийг тусгажээ. Үүнд:

- Сургуулийн дүрэмд 12 сургууль
- Дотоод журамд 17 сургууль
- Багш ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод 7 сургууль
- Хөдөлмөрийн гэрээнд 3 сургууль
- Эцэг эх, орон нутгийн байгууллагатай ажиллах журам, хамтын ажиллагааны гэрээнд 3 сургууль

СХД-ийн 65 дугаар сургуулийн багш нарын зөвлөлийн
2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн
анхдугаар хурлаар хэлэлцэж батлав.

НИЙСЛЭЛИЙН СХД-ИЙН 65 ДУГААР СУРГУУЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл



- 1.1 Сургуулийн нэр : Нийслэлийн СХД-ийн 65 дугаар сургууль
- 1.2 Сургуулийн хаяг: Нийслэлийн СХД-ийн 3 дугаар хороо
- 1.3 СХД-ийн 65 дугаар сургууль нь боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд түвшний боловсрол эзэмшүүлэх ердийн сургалтын хэв шинжтэй сургалтын байгууллага юм.
- 1.4 Тус сургууль нь үйл ажиллагаандаа Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Гэр бүлийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр, холбогдох бусад хууль тогтоомжийг баримтлан ажиллахаас гадна энэхүү дүрмийг баримтлан ажиллана.
- 1.5 Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь:
 - Бага боловсролыг эх хэлний суурь чадамжийг эзэмших боломжийг бүрдүүлэн бүтээлч, сурах арга барилтай зөв монгол хүүхэд төлөвших үе
 - Суурь боловсролыг амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг чадвар, бие даан суралцах бүтээлчээр суралцах чадамж эзэмших үе
 - Бүрэн дунд боловсролыг уян хатан, сонголттой хөтөлбөрөөр мэдээлэл боловсруулах шийдвэр гаргах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь баримжаа олгох үе хэмээн хөгжүүлнэ.
- 1.6 Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх нийтлэг зарчим, бүрэн эрх, бусад байгууллага, иргэдтэй харилцах хэм хэмжээг тодорхойлж, сургуулийн үйл ажиллагааг зохицуулахад энэхүү дүрмийг баримтлана.

Хоёр. Сургуулийн эрх үүрэг, сургалтын үйл ажиллагаа

2.1 Сургуулийн эрх, үүрэг

- 2.1.1 Сургууль нь Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль хуульд заасан чиг үүргээс гадна дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.1.2 МУ-ын Хөдөлмөр, Боловсролын, БДБ-ын, төсвийн удирдлага санхүүжилтийн,
 - Төрийн албаны тухай хууль
 - МУ-ын ЗГ-ын мөрийн хөтөлбөр
 - МУ-ын Боловсролыг 2006–2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө
 - Нийслэлийн боловсролыг 2006–2015 онд хөгжүүлэх төлөвлөгөө
 - Нийслэл болон дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөр бусад хууль, тогтоол, тушаалыг хэрэгжүүлэн, түүнд нийцүүлэн зохих шийдвэр гаргаж ажиллана.
- 2.1.3 БСШУ-ны сайдын 2007 оны 351 дүгээр тушаалаар баталсан багш нар, сургалтын менежер, нийгмийн ажилтан, эмчийн ажлын байрны тодорхойлолтыг мөрдөж ажиллана.
- 2.1.4 Хичээлийн жилийн эхэнд ажилд шинээр орсон багш бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулж жилд 1 удаа дүгнэнэ. Шаардлагатай үед сургуулийн ҮЭХорооны төлөөлөл оролцоно.
- 2.1.5 Гадаад, дотоодын тэргүүний сургууль, багш нарын туршлагаас суралцах, өөрийн сургуулийн тэргүүний багш нарын туршлагыг бусдад түүгэн дэлгэрүүлэх бололцоогоор хангах, үйл ажиллагааг зохион байгуулна.
- 2.1.6 Залуу багш нарыг туршлагатай багш нартай хамтран ажиллуулах боломжоор хангаж, тэдэнд сэтгэл зүйн болон бусад дэмжлэг урамшуулал үзүүлнэ.
- 2.1.7 Үр бүтээлтэй ажиллаж байгаа багш, ажилчдыг төр засгийн болон яам, удирдах дээд байгууллага, хот, дүүрэг, олон нийтийн байгууллагын шагналар шагнуулах ба шагнуулахаар тодорхойлно.

СХД-ийн 65 дугаар сургуулийн багш нарын зөвлөлийн
2016 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн
анхдугаар хурлаар хэлэлцэж батлав.

НИЙСЛЭЛИЙН СХД-ИЙН 65 ДУГААР СУРГУУЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл



- 1.1 Сургуулийн нэр : Нийслэлийн СХД-ийн 65 дугаар сургууль
- 1.2 Сургуулийн хаяг: Нийслэлийн СХД-ийн 3 дугаар хороо
- 1.3 СХД-ийн 65 дугаар сургууль нь боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд түвшний боловсрол эзэмшүүлэх ердийн сургалтын хэв шинжтэй сургалтын байгууллага юм.
- 1.4 Тус сургууль нь үйл ажиллагаандаа Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Гэр бүлийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр холбогдох бусад хууль тогтоомжийг баримтлан ажиллахаас гадна энэхүү дүрмийг баримтлан ажиллана.
- 1.5 Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь:
 - Бага боловсролыг эх хэлний суурь чадамжийг эзэмших боломжийг бүрдүүлэн бүтээлч, сурах арга барилтай зөв монгол хүүхэд төлөвших үе
 - Суурь боловсролыг амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг чадвар, бие даан суралцах бүтээлчээр суралцах чадамж эзэмших үе
 - Бүрэн дунд боловсролыг уян хатан, сонголттой хөтөлбөрөөр мэдээлэл боловсруулах шийдвэр гаргах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь баримжаа олгох үе хэмээн хөгжүүлнэ.
- 1.6 Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх нийтлэг зарчим, бүрэн эрх, бусад байгууллага, иргэдтэй харилцах хэм хэмжээг тодорхойлж, сургуулийн үйл ажиллагааг зохицуулахад энэхүү дүрмийг баримтлана.

Хоёр. Сургуулийн эрх үүрэг, сургалтын үйл ажиллагаа

2.1 Сургуулийн эрх, үүрэг

- 2.1.1 Сургууль нь Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, хуульд заасан чиг үүргээс гадна дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.1.2 МУ-ын Хөдөлмөр, Боловсролын, БДБ-ын, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, тогтоол, тушаалыг хэрэгжүүлэн, түүнд нийцүүлэн зохих шийдвэр гаргаж ажиллана.
- 2.1.3 БСШУ-ны сайдын 2007 оны 351 дүгээр тушаалаар баталсан багш , сургалтын менежер, нийгмийн ажилтан, эмч, номын санч, дотоод хяналт шалгалтын нэгжийн ажилтны ажлын байрны тодорхойлолтыг мөрдөж ажиллана.
- 2.1.4 Хичээлийн жилийн эхэнд ажилд шинээр орсон багш бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулж жилд 1 удаа дүгнэнэ. Шаардлагатай үед сургуулийн ҮЭХорооны төлөөлөл оролцоно.
- 2.1.5 Гадаад, дотоодын тэргүүний сургууль, багш нарын туршлагаас суралцах, өөрийн сургуулийн тэргүүний багш нарын туршлагыг бусдад түүгэн дэлгэрүүлэх бололцоогоор хангах, үйл ажиллагааг зохион байгуулна.
- 2.1.6 Залуу багш нарыг туршлагатай багш нартай хамтран ажиллуулах боломжоор хангаж, тэдэнд сэтгэл зүйн болон бусад дэмжлэг урамшуулал үзүүлнэ.
- 2.1.7 1-р ангийг даан авч ажиллаж байгаа багш нарт Бэлтгэл хөтөлбөр, Тайлант уншлагын үр дүнг харгалзан 2 удаа урамшил олгоно.
- 2.1.8 Үр бүтээлтэй ажиллаж байгаа багш, ажилчдыг төр засгийн болон яам, удирдах дээд байгууллага, хот, дүүрэг, олон нийтийн байгууллагын шагналар шагнуулах ба шагнуулахаар тодорхойлно.
- 2.1.9 Сургууль нь бие даасан хуулийн этгээд байх бөгөөд зохих журмын дагуу үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг хэрэглэх ба өөрийн бэлгэдэлтэй байж болно.

Сонгонохйрхан дүүргийн 65-р сургуулийн дүрэмд оруулсан өөрчлөлтүүд хичээлийн жилээр харьцуулав.

- 2.1.10 Сургуулийн үйл ажиллагаанд холбогдох статистик, бүртгэл мэдээллийг бүрэн хөтөлж, ангийн журнал, суралцагч, төгсөгчдийн сурлагын дүн, боловсролын баримт бичиг нөхөн олголтын материал болон санхүүгийн тайланг архивт цаасан болон цахим хэлбэрээр хадгална.
- 2.1.11 Сургуулийн үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг суралцагч, эцэг эхэд үнэ төлбөргүй өгч, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллана.
- 2.1.12 Сургууль нь хүүхдийн эрхийг дээдэлсэн, ардчилал, шударга ёс, ил тод байдал, хамтын удирдлагын зарчимд тулгуурлан үйл ажиллагаагаа зохион байгуулах ба хүүхэд хамгааллын тусгайланс бодлого, дэд хөтөлбөрүүдийг боловсруулан мөрдөж ажиллана.
- 2.1.13 Сургууль нь суралцагчдын зөвлөл болон хүүхдийн оролцооны байгууллагуудыг дэмжин ажиллана.
- 2.1.14 Сургалтын үйл явц, чанар, үр дүнд өөрийн үнэлгээ өгөх чиг үүрэг бүхий багш, суралцагч, эцэг эх, төрийн ба төрийн бус байгууллагын төлөөлөөс бүрдсэн хяналт шинжилгээний баг ажиллуулна.
- 2.1.15 Сургуулийн хэмжээнд бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөн туслах менежментийн баг ажиллана. Баг нь сургуулийн удирдлага, мэргэжлийн зэрэгтэй суралцагч багш нарын төлөөлөөс бүрдсэн 9-11 хүний бүрэлдэхүүнтэй байх ба багийг жилд 1 удаа өөрчилнө.
- 2.1.16 Зөвлөн туслах менежментийн баг нь сургуулийн хөтөлбөрт зөвлөгөө өгч, сонголтод орох эрхийг олгоно. Багийн гишүүдэд ажлын үр дүнг харгалзан урамшил олгоно.
- 2.1.17 СХД-ийн 3, 4, 26 дугаар хорооны хүүхдийг насанд нь 1-р ангид элсүүлэн сургах бөгөөд сургууль завсардуулахгүй суурь боловсролыг 100% эзэмшүүлж, сургууль завсардсан хүүхдийг сургуульд буцаан суралцуулах ажлыг зохион байгуулна.
- 2.1.18 Сургууль нь хамран сургах 3, 4, 26 дугаар хорооны 1-р ангид элсэх суралцагчдын судалгааг жил бүр хорооноос авч элсүүлэх ажлыг журмын дагуу зохион байгуулна.
- 2.1.19 10-р ангид элсэн суралцагчдыг тухайн хичээлийн жилийн улсын шалгалтын комисс, анги нэгдэл нээлттэй зохион байгуулна.
- 2.1.20 Нэгдүгээр ангид шинээр элсэгчдийг бүртгэлийг 4 дүгээр ангийн М3АСекц зохион байгуулж, угтан авах ёслолыг 1 дүгээр ангийн М3АСекц хариуцна.
- 2.1.21 Бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчдөд боловсролын баримт бичиг /үнэмлэх/, суралцагчийн хувийн хэргийг хүндэтгэлтэйгээр гардуулах төгсөлтийн барын арга хэмжээг зохион байгуулна.
- 2.1.22 Сургууль эцэг эхийн хороотой байх бөгөөд дүрмийг нийт эцэг эхийн хурлаар баталж мөрдөнө.
- 2.1.23 Сургууль энэхүү дүрмээс гадна дараах дүрэм журам, зааврыг боловсруулна. Үүнд: сургуулийн дотоод журам, хамтын гэрээ, заах аргын нэгдэл секцийн ажиллах журам, тэргүүний нэгдэл, секц, анги нэгдэл, анги, багш, суралцагч, ажилчныг шалгаруулах журам, багшийн хариуцлагын картын журмыг мөрдөж ажиллана.

2.2. Сургалтын үйл ажиллагаа

- 2.2.1 Сургалтын үйл ажиллагаанд бага, суурь, бүрэн дунд боловсролын шинэчилсэн цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, хичээлийн жилийн бүтэц, зорилго зорилтыг баримтлан ажиллана.
- 2.2.2 Сургууль сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу суралцагчдад бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулна.
- 2.2.3 Сургалтын үйл ажиллагаа нь суралцагчийн эрхийг хүндэтгэсэн, бие даан бүтээлчээр суралцах, үйл явцыг дэмжсэн, нас, бие, сэтгэхүйн хөгжлийн онцлогийг харгалзан, суралцагчдад суралцах боломжийг адил тэгш олгосон байна.
- 2.2.4 Сургалтын ажил нь хичээл, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, амьдрах ухааны чадварт суралцах үйл ажиллагаанаас бүрдэнэ. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь хүүхдийг төлөвшүүлэх, хүн байх эрдэм ухааныг эзэмшүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөртэй ажиллана.
- 2.2.5 Бага, дунд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрт нийцүүлэн өөрийн онцлогийг тусгасан сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулж мөрдөж ажиллана.
- 2.2.6 Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн сургалтанд хамрагдсан багш нарын багийг байгуулж бусад багш нарт түүгээр дэлгэрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

- 2.1.8 Сургууль нь бие даасан хуулийн этгээд байх бөгөөд зохих журмын дагуу үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг хэрэглэх ба өөрийн бэлгэдэлтэй байж болно.
- 2.1.9 Сургуулийн үйл ажиллагаанд холбогдох статистик, бүртгэл мэдээллийг бүрэн хөтөлж, ангийн журнал, суралцагч, төгсөгчдийн сурлагын дүн, боловсролын баримт бичиг нөхөн олголтын материал болон санхүүгийн тайланг архивт цаасан болон цахим хэлбэрээр хадгална.
- 2.1.10 Сургуулийн үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг суралцагч, эцэг эхэд үнэ төлбөргүй өгч, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллана.
- 2.1.11 Сургууль нь хүүхдийн эрхийг дээдэлсэн, ардчилал, шударга ёс, ил тод байдал, хамтын удирдлагын зарчимд тулгуурлан үйл ажиллагаагаа зохион байгуулах ба хүүхэд хамгааллын тусгайланс бодлого, дэд хөтөлбөрүүдийг боловсруулан мөрдөж ажиллана.
- 2.1.12 Сургууль нь сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах эрүүл орчин, аюулгүй байдлын талаарх стратеги төлөвлөгөөг боловсруулан мөрдөж ажиллана.
- 2.1.13 Сургууль нь суралцагчдын зөвлөл болон хүүхдийн оролцооны байгууллагуудыг дэмжин ажиллана.
- 2.1.14 Сургалтын үйл явц, чанар, үр дүнд өөрийн үнэлгээ өгөх чиг үүрэг бүхий багш, суралцагч, эцэг эх, төрийн ба төрийн бус байгууллагын төлөөлөөс бүрдсэн хяналт шинжилгээний баг ажиллуулна.
- 2.1.15 Сургуулийн удирдлагын мэдээллийн системийг бүрдүүлж, мэдээллийн нууцлал, аюулгүй ажиллагааг ханган ажиллана.
- 2.1.16 Тус сургууль нь СХД-ийн 3, 4, 26 дугаар хорооны хүүхдийг сургууль завсардуулахгүй сургах бөгөөд суурь боловсролыг 100% эзэмшүүлж, сургууль завсардсан хүүхдийг сургуульд буцаан суралцуулах ажлыг зохион байгуулна.
- 2.1.17 Сургууль нь хамран сургах 3, 4, 26 дугаар хорооны суурь боловсрол эзэмших насны хүүхдийн судалгааг жил бүр шинэчлэн гаргах, суралцагчийг элсүүлэх ажлыг журмын дагуу тухайн хичээлийн жилийн улсын шалгалтын комисс, 9 дүгээр ангийн анги нэгдэл хамтран нээлттэй зохион байгуулна.
- 2.1.18 Нэгдүгээр ангид шинээр элсэгчдийг тухайн хичээлийн жилийн 4 дүгээр ангийн М3АСекц зохион байгуулж, угтан авах ёслолыг 5 дугаар ангийн М3АСекц хариуцна.
- 2.1.19 Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн төгсөгчдөд боловсролын баримт бичиг /гэрчилгээ, үнэмлэх/, суралцагчийн хувийн хэргийг хүндэтгэлтэйгээр гардуулах төгсөлтийн барын арга хэмжээг зөвхөн 12 дугаар ангид зохион байгуулах бөгөөд 1-р ангийн усалгээний баярыг эцэг эхийн нэрэмжит "Тайлант уншлага" хэлбэрээр зохион байгуулна.
- 2.1.20 Сургууль эцэг эхийн зөвлөлтэй байх бөгөөд эцэг эхийн зөвлөлийн дүрмийг нийт эцэг эхийн хурлаар баталж мөрдөнө.
- 2.1.21 Сургууль энэхүү дүрмээс гадна дараах дүрэм журам, зааврыг боловсруулна. Үүнд: сургуулийн дотоод журам, хамтын гэрээ, заах аргын нэгдэл секцийн ажиллах журам, багш нарыг үнэлж дүгнэх журам, анги удирдсан багшид нэмэгдэл хөс олгох журам, тэргүүний суралцагч анги хамт олон шалгаруулах журам, өргөдөл гомдол хүлээн авах шийдвэрлэх журмыг хамт олны хурлаар хэлэлцүүлэн мөрдөж ажиллана.

2.2. Сургалтын үйл ажиллагаа

- 2.2.1 Сургалтын үйл ажиллагаанд хүчин төгөлдөр үйлчилж буй бага боловсролын шинэчилсэн цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх суурь, бүрэн дунд боловсролын стандарт, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан сургалтын талаар баримтлах бодлого, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, хичээлийн жилийн бүтэц, зорилго зорилтыг баримтлан ажиллана.
- 2.2.2 Сургууль сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу суралцагчдад бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулна.
- 2.2.3 Сургалтын үйл ажиллагаа нь суралцагчийн эрхийг хүндэтгэсэн, бие даан бүтээлчээр суралцах, үйл явцыг дэмжсэн, нас, бие, сэтгэхүйн хөгжлийн онцлогийг харгалзан, суралцагчдад суралцах боломжийг адил тэгш олгосон байна.
- 2.2.4 Сургалтын ажил нь хичээл, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, амьдрах ухааны чадварт суралцах үйл ажиллагаанаас бүрдэнэ. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь

Сонгинохайрхан дүүргийн 65-р сургуулийн дүрэмд оруулсан өөрчлөлтүүд хичээлийн жилээр харьцуулав.

<p>алдаагүй утга найруулгын өндөр түвшинд бичиж баталгаажуулах</p> <p>27. Байгууллагын хэмжээнд үйлдэгдсэн болон гаднаас ирсэн албан баримт бичгүүдийг зохих журмын дагуу архивлах</p> <p>28. Архивын бичиг баримтын хадгалалт хамгаалалтын горим, аюулгүй байдалд онцгой анхаарч ажиллах</p> <p>29. Өөрийн мэдлэг боловсролоо тасралтгүй дээшлүүлэх, сургалт семинарт хамрагдах, бүхий л цахим болон сүлжээний техник хэрэгсэл дээр ажиллах чадвартай байх</p> <p>30. Бие даан асуудал шийдвэрлэх, хариуцлага хүлээх чадвартай байж албан бичиг хэргийн нууцлалыг хадгалах</p> <p>31. Сургуулийн цахилгаанчин нь анги танхим, нийтийн эзэмшлийн газрын цахилгааны найдвартай ажиллагааг хангаж ажиллах</p> <p>32. Цахилгааны шит, холболтыг байнга шалгаж болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх гэмтэл согогийг тухай бүрд нь илрүүлж засах, сургуулийн захиргаанд мэдэгдэх, мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран ажиллах ажлыг цаг алдахгүй гүйцэтгэх</p> <p>33. Аюулгүй ажиллагааны анхааруулга, зөвлөмж, зааварчилгааг шаардлагатай үед багш ажиллагсад, сурагчдад өгөх</p> <p>34. Хариуцсан багаж хэрэгслэлээ хайр хамтай ашиглах, бэлэн байлгах, нөөц бүрдүүлэх</p> <p>35. Слесарь нь сургуулийн халаалт дулааны найдвартай ажиллагааг хангаж ажиллах</p>	<p>байгуулах</p> <p>26. Шаардлагатай ном хэвлэлийг захиалах, худалдан авах, данс бүртгэлд тусгах картлах ажлыг санхүүтэй хамтран зохион байгуулах</p> <p>27. Ашиглагдахгүй болсон, хэт хуучирсан номыг данс бүртгэлээс хасах ажлыг зохих журмын дагуу өмч хамгаалах байнгын зөвлөлтэй хамтран зохион байгуулах</p> <p>28. Японы хүүхдийг ивээх сантай хамтран хэрэгжүүлж буй "I ангийн сурагчдын сурах чадварыг дэмжихэд чиглэсэн сургуулийн чадавхыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд сургуулийн номын санч нь</p> <p>26.1. I ангийн багш эцэг эхчүүд "Уншигчдын клуб"-ын сурагчидтай хамтран I ангийн сурагчдын онцлогт тохирсон шинэлэг үйл ажиллагааг зохион байгуулах</p> <p>26.2. Эцэг эхчүүдийн дунд тэдний идэвх санаачлагыг өрнүүлсэн уралдаан тэмцээнийг зохион байгуулах</p> <p>26.3. Сургуулийн номын санг I ангийн сурагчдад зориулсан том үсэг, тод зурагтай, үйл явдал номын баатруудаар нэрлэсэн хүүхдийн сонирхлыг татахуйц дизайн зохиомжтой номуудаар баяжуулах, сурталчлах, ашиглуулах</p> <p>29. Сургуулийн архив, бичиг хэргийн ажилтан нь албан бичиг хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаатай холбогдох эрх зүйн хүрээнд байгууллагын хэмжээнд үйлдэгдэх баримт бичгүүдийг төлөвлөх бичих баталгаажуулах ажлыг гардан зохион байгуулах</p> <p>30. Албан бичиг баримт хөтлөх стандарт, дүрэм зааврыг чанд</p>
---	--

Сонгинохайрхан дүүргийн 104 дүгээр сургуулийн дүрэмд оруулсан өөрчлөлтүүд.

2013-2014 оны хичээлийн жилд мөрдөгдсөн дотоод журам	2017-2018 оны хичээлийн жилд мөрдөгдөж буй дотоод журам
СУРГАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ	
<ol style="list-style-type: none"> 1. Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хуваарийг цаг хугацаанд нь бэлэн болгож мөрдүүлэх шаардлагатай үед богино хугацаанд зохицуулалт хийнэ. 2. Багш нарын нэгж хичээлийн хөтөлбөр хэрэглэгдэхүүн бусад бичиг баримтыг тогтмол шалгаж тооцон хяналт тавихын зэрэгцээ тэдэнд зөвлөх, дэмжих үйл ажиллагааг зохион байгуулна. 3. Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, агуулгын хүрээ, зөвлөмжийг багш бүрээр судлуулах, мэргэжлийн зөвлөлтгөө өгөх, нэгж хичээлийн хөтөлбөр, арга зүйн боловсруулалт хийх ажлыг удирдана. 4. Боловсролын стандартыг багш бүрээр хангуулах ажлыг гол удирдлага болгож, багш бүртэй тулж, тооцоо судалгаагаар ажиглана. 5. Улиралд нэгээс доошгүй удаа журнал, бичиг баримтын хөтлөлттэй танилцаж дүгнэлт гарган гарсан дутагдлыг арилгуулна. 6. Багш бүрээр сэдвийн шалгалтын дүнг заавал гаргуулж, хөндлөнгийн шалгалтыг графикайн дагуу авч, багшийн сургалтын ажилд үнэлэлт дүгнэлт өгнө. 7. Цалин, илүү цагийн болон бусад нэмэгдлүүд, улирлын ажлын үр дүнгийн урамшлыг цаг хугацаанд нь үнэн зөв бичиж багш нарт танилцуулж захирлаар батлуулж санхүүд өгч байна. 8. Багшлах эрх, мэргэжлийн зэрэг авах болон ажлаараа 	<ol style="list-style-type: none"> 1. Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хуваарийг цаг хугацаанд нь бэлэн болгож мөрдүүлэх шаардлагатай үед богино хугацаанд зохицуулалт хийнэ. 2. Багш нарын нэгж хичээлийн хөтөлбөр хэрэглэгдэхүүн бусад бичиг баримтыг тогтмол шалгаж тооцон хяналт тавихын зэрэгцээ тэдэнд зөвлөх, дэмжих үйл ажиллагааг зохион байгуулна. 3. Боловсролын стандарт, бага суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр, Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын 01, 03 тоот албан даалгавар, цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмжийн багш бүрээр судлуулах, мэргэжлийн зөвлөлтгөө өгөх, нэгж хичээлийн хөтөлбөрийн арга зүйн боловсруулалт хийх ажлыг удирдана. 4. Боловсролын стандартыг багш бүрээр хангуулах ажлыг гол удирдлага болгож багш бүрд тулж, тооцоо судалгаагаар ажиглана. 5. Улиралд нэгээс доошгүй удаа журнал бичиг баримтыг хөтлөлттэй танилцаж дүгнэлт гарган гарсан дутагдлыг арилгуулна. 6. Багш бүрээр явцын үнэлгээг тогтмол хийлгэж, хөндлөнгийн хяналтыг графикайн дагуу авч багшийн сургалтын ажил болон суралцагчдын ахиц амжилтад үнэлэлт дүгнэлт өгч ажиглана. 7. Цалин, илүү цагийн болон бусад нэмэгдлүүд, улирлын ажлын үр дүнгийн урамшлыг цаг хугацаанд нь үнэн зөв бичиж багш нарт

Сонгинохайрхан дүүргийн 104 дүгээр сургуулийн дүрэмд оруулсан өөрчлөлтүүд.



ҮР ДҮН

- Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд дасан зохицох, суралцах чадварыг дэмжих талаарх сургуулийн бодлогыг шинээр боловсруулж мөрдөж хэрэгжүүлдэг болсон.
- Нэгдүгээр ангийн сурагчдыг дэмжих үйл ажиллагаа нь сургуулийн эрхзүйн баримт бичгүүдээр баталгаажсанаар сургуулийн захирал, бага ангийн сургалтын менежер, багш, эмч, номын санч, нийгмийн ажилтнуудын үүрэг хариуцлага сайжирч, хамтын ажиллагаа бэхэжсэн.
- Сургууль, эцэг эх, орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирсан.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Эрхзүйн бичиг баримтыг сайтар хэлэлцүүлэн баталгаажуулсанаар урт хугацаанд хэрэгжих тогтвортой байдлыг бий болгож чадсан байна.

ТӨСӨЛД ХАМРАГДСАН СУРГУУЛИУД



САЙН ТУРШЛАГА

Орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Төслийн зорилтот бүх сургууль



ЗОРИЛТОТ БҮЛЭГ

Сургалтын менежер, бага ангийн багш нарын заах аргын нэгдэл

ЗОРИЛГО

Сургуулийн бодлого, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд харьяа тойргийн хороо, цэцэрлэг, өрхийн эмнэлэг зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай байнгын тогтвортой түншлэлийг ханган ажиллах



АРГАЗҮЙ

Сургуулиас орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах нь хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал, дасан зохицох үйл явцад эергээр нөлөөлдөг.

Чингэлтэй дүүргийн 37-р сургууль харьяа тойргийн цэцэрлэг, хороо, өрхийн эмнэлэгтэй хичээлийн жилийн эхлэхээс өмнө холбоо тогтоож, хамтарсан уулзалт зохион байгуулдаг. Энэхүү уулзалтыг төслийн хүрээнд боловсруулсан “Хамтын ажиллагааны хөтөч” аргачлалаар зохион байгуулдаг. Уг аргачлалыг ашиглан байгууллагууд нэгдүгээр ангийн сурагчдыг хэрхэн дэмжиж, хамтран ажиллаж буй нөхцөл байдалдаа хамтран дүн шинжилгээ хийж, өөрсдийн давуу, сул тал бэрхшээл, боломжийг дүгнэн хүүхдийн сургуульд бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг дэмжих хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, гэрээ байгуулан ажилладаг.

Хамтын ажиллагааны төлөвлөгөөг сургуулийн дасан зохицох, суралцах чадварыг дэмжих хөтөлбөрт тусган шаардлагатай зохион байгуулалтыг хийсэн. Тухайлбал, цэцэрлэгийн багш нар хүүхдүүдтэйгээ сургуультай танилцах аяллыг зохион байгуулах, хичээлийн үйл ажиллагаатай танилцах, өрхийн эмнэлэг хүүхдэд зориулсан эрүүл ахуйн сургалт явуулах, эрүүл мэндийн үзлэг хийх, хорооны ажилтан хөгжлийн бэрхшээлтэй, ар гэр амьдралын боломж тааруу, харьяа бус зэрэг шалтгаанаар хамтран сургах тойргийн сургуульдаа сурч чадахгүй байгаа

хүүхдүүдийн талаарх мэдээллээр ханган сургуульд хамрагдахад нь туслах, цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийг гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэхэд туслах, хорооны цагдаа замын хөдөлгөөний аюулгүй байдлаар болон анхаарал болгоомжтой байх талаар хичээл заах зэрэг хүүхдийн төлөө үйл ажиллагааг явуулсаар байна. Дээрх хамтарсан уулзалтыг тогтмолжуулж, төлөвлөн хийсэн ажлаа хамтран дүгнэх, хамтын ажиллагаагаа сайжруулах ажлуудыг зохион байгуулсан.

Орон нутгийн түвшинд хамтын ажиллагааг хангах төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаанд ашиглах хичээл

Зорилго: 1. Орлогчид, "ДССЧХ"-ийн талаар ойлголтой болж, нэгдүгээр аялал орончид оролцох боломж байдалтай болж, орон нутгийн ажилтан, орлогчид ажиллаж үзүүлэхэд хамтран ажиллаж үйл явдал болж, дагуу болон сурталчид түрүүлж (ахлах) хамтран ажиллах чиглэлтэй төлөвлөгөө боловсруулах.

Орончид:

- Мэдлийн үндсэн сургалтын орлогчид 6
- Сургуулийн удирдлагын баг-3
- Бүх бага ангийн багш
- Түүш байгууллагын төлөөлөл 6 (цэцэрлэг, хороо, өрхийн эмгэгч)

Календэр

#	Үйл ажиллагаа	Ашиглах материал
1	"ДССЧХ"-ийн хамтарсан тухай ойлголт	"ДССЧХ"-ийн гарын авлага Алхам 1
2	Календэр дэх туншлан ажлын ажиллагааны тухай ойлголт	
4	Хамтран байгууллагын талаар мэдээлэл оруулах	Алхам 2
5	Хамтран байгууллагуудын оролцоогийн мэдээлэл оруулах	Алхам 3
6	Хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулах	Алхам 4

Зөвлөх

"Зөвлөх хичээл нь төлөвлөгөөний хийх 3 үе шатанд төлөвлөх чиглэлтэй болж дараа хичээлүүдийг бэлдэн үйл ажиллагаанд ашиглах явдал байдаг. Өөрийн төлөвлөгөөгөө амжилттай биелүүлж, үр дүнтэй ажиллаж үзүүлэхэд хамтран ажиллах чиглэлтэй төлөвлөгөө боловсруулах бусад ажиллагаанд хамтран ажиллах чиглэлтэй төлөвлөгөө боловсруулах.

Орончид:

- Туслах сургалтанд оролцогчид 6
- Сургуулийн удирдлагын баг-3
- Бүх бага ангийн багш
- Хамтарчид-6

Алхам 1:

Төлөвлөгөөний үндэсний төлөвлөгөөний тухай ойлголт оруулах.

Төлөвлөгөөний үндэсний төлөвлөгөөний тухай ойлголт оруулах.

Төлөвлөгөөний үндэсний төлөвлөгөөний тухай ойлголт оруулах.


Төлөвлөгөөний үндэсний төлөвлөгөөний тухай ойлголт оруулах.

✓ ҮР ДҮН

Сургууль болон харьяа тойргийн байгууллагуудын тогтмол хамтын ажиллагаа бий болсон. Нэгдүгээр ангийн сурагчдын сургуульд бэлэн байдлыг хангах ажлын чиглэлээр сургуулийн зүгээс санаачлан орон нутгийн байгууллагуудтай хамтран ажилласнаар хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал, эрүүл мэнд, бүртгэл мэдээлэл, орчны аюулгүй байдал, дасан зохицох чадвар сайжирсан.

👥 ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Хамтын ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэхэд сургуулийн санаачилга, төлөвлөлт хамгийн чухал үүрэгтэй. Хамтын ажиллагааг гэрээ, төлөвлөгөөгөөр баталгаажуулан үйл ажиллагаагаа үнэлж хянаж байх шаардлагатай.



ТӨСӨЛД ХАМРАГДСАН СУРГУУЛИУД



САЙН ТУРШЛАГА

Сургуулийн орчинд нэгдүгээр ангийн сурагчдад зориулсан тэмдэг, тэмдэглэгээг бий болгох



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Төслийн зорилтот бүх сургууль



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Сургуулийн захиргаа

ЗОРИЛГО

1-р ангийн сурагчдад сургуулийн орчинд дасан зохицоход дэмжлэг болохуйц тэмдэг, тэмдэглэгээг бий болгох




АРГАЗҮЙ

Сургууль бүр үлгэрийн баатар, хүүхэлдэйн киноноос сэдэвлэсэн, хүүхдэд сонирхолтой, ойлгомжтой тэмдэг тэмдэглэгээг хүүхдийн оролцоонд тулгуурласан зургийн уралдаанаар шалгаруулж шилдэг бүтээлүүдийг тэмдэг, тэмдэглэгээ болгон сургуулийн дотоод болон гадаад орчинд байрлуулсан. Эдгээр тэмдэг, тэмдэглэгээг нэгдүгээр ангийн хичээлийн танхим, номын сан, биеийн тамирын заал, дуу хөгжмийн танхим, цайны газар, бие засах газар, сургуулийн ажилтнуудын өрөөнд байрлуулсан. Түүнчлэн сургуулийн гадна орчинд уурын зуух, нүх зэрэг хүүхдэд аюултай газруудад анхааруулах тэмдэглэгээ тавьсан.

Зарим тэмдэглэгээг хичээлийн жилийн эхэнд зурган хэлбэрээр хийж, хүүхдийн харааны түвшинд байрлуулсан. Эдгээр зурган тэмдэглэгээг сургуулийн танилцуулгад тайлбартай нь оруулснаас гадна сургуультай танилцах аяллын үеэр хүүхдүүдэд танилцуулан нүдлүүлдэг.

Нэгдүгээр ангийн сурагчдад зориулсан таних тэмдгүүдийг агуулсан сургуулийн дотоод болон гадна орчны зураглал боловсруулж давхар бүрт байрлуулсан.

Үүнээс гадна зарим сургуулиуд нэгдүгээр ангийн сурагчдын энгэрийн таних тэмдэг хийж зүүлгэсэн. Ингэснээр тухайн сургуулийн бүх ажилчид, сурагчид, багш, эцэг эхчүүд тэдэнд шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэх боломжтой.



✓ ҮР ДҮН

- Хүүхэд сургуулийн орчинтой хурдан танилцаж дасахад дөхөм үзүүлнэ.
- Уншиж сураагүй хүүхдүүд бие даан анги танхим, бусад газруудыг хялбархан олно.
- Сургууль, ангийн дэгийг ойлгон мөрдөнө.
- Хүүхдийг болзошгүй эрсдэлээс хамгаална.

👁️ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Байршуулсан тэмдэг, тэмдэглэгээг шинээр сургуульд элсэн орж байгаа хүүхдүүдэд таниулан, сэргээн засварлах замаар сургууль тогтмол ашиглана.

37, 117-Р СУРГУУЛИУД



САЙН ТУРШЛАГА

“Сургуультай танилцах аялал”



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Чингэлтэй дүүргийн 37, 117
дугаар бүрэн дунд сургууль



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Бага ангийн заах аргын
нэгдэл, нийгмийн ажилтан

ЗОРИЛГО

Нэгдүгээр ангийн сурагчдыг сургуульд дасан зохицох үйл явцыг дэмжих



АРГАЗҮЙ

Сургуульд элсэн орох нь хүүхдийн амьдралд том өөрчлөлт авч ирдэг. Тиймээс анх сургуульд орж байгаа хүүхэд дасан зохицоход хамгийн түрүүнд тохиолдож буй бэрхшээл болох “үл таних ертөнц”-ийг тэдэнд ойртуулах нь зайлшгүй шаардлагатай. Сургуультай танилцах аялал нь сургуулийн дотоод болон гадаад орчны талаар эерэг зөв сэтгэгдлийг хүүхдэд өгөхөд чухал нөлөөтэй ажил болдог.

Цэцэрлэгт хамрагддаг хүүхдүүдийг сургуульд бэлтгэх талаар сургууль цэцэрлэгийн багш нартай хамтарсан уулзалтыг зохион байгуулж, сургуультай танилцах аяллыг ажлын төлөвлөгөөндөө тусган хариуцах ажлаа харилцан тохиролцдог.

Цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдийг сургуульд бүртгэх бүртгэлийн үеэр эцэг эхчүүдэд сургуультай танилцах аяллын урилгыг өгч болдог.

Сургуультай танилцах аяллыг хавар 1 удаа сургуулийн дотоод орчноор, намар 1 удаа гадаад орчноор явуулах нь үр дүнтэй. Аялал зохион байгуулахад дараах бэлтгэлийг урьдчилан хангаж ажилладаг.

Үүнд:

- Аяллын өдрөө товлох
- Аялалд оролцох хүүхдийн тоог гаргах
- Аялах газрынхаа таних тэмдэг, тэмдэглэгээг бэлтгэх
- Аялал хийх сургуулийн гадаад болон дотоод орчны зургийг бэлтгэх

- Аялалд оролцох урилгыг цэцэрлэгийн багш нараар дамжуулан эцэг эхчүүдэд гардуулж өгөх. Цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдийн урилгыг бүртгэлийн үеэр эцэг эхчүүдэд өгөх (Урилгыг урьдчилан бэлтгэх нь зөв байдаг)
- Аяллыг удирдан зохион байгуулах багш, ажилтнуудыг томилох (шинэ хичээлийн жилд 1-р анги дааж авах багш нарыг сонгох нь зүйтэй)
- Аюулгүй байдлыг хангахад анхаарах



Анхаарах зүйлс: Аялах өдрийн цаг агаарыг урьдчилан нягтлаарай. Хэрэв аялалд хамрагдах хүүхдийн тоо их байвал аяллын өдөр төлөвлөхдөө үүнийг харгалзах нь чухал. Сургуулийн дотоод орчин буюу сургуулийн бие засах газар, шатны чиглэл, захирлын болон сургалтын менежерийн өрөө, эмч, номын сан, биеийн тамирын заал, цайны газрын таних тэмдэг, сургуулийн гадна талын машины зогсоол, эрсдэлтэй газрын таних тэмдгийг заавал бэлтгэсэн байх хэрэгтэй. Сургуулиар аялж буй хүүхдүүдэд бяцхан гарын бэлэг өгөх нь тэдэнд сайхан сэтгэгдлийг төрүүлдэг. Гэхдээ хүүхдийн эрүүл ахуйд хортой бүтээгдэхүүн өгөхөөс татгалзах нь зүйтэй.



ҮР ДҮН

Сургууль орчин, суралцах анги танхимтайгаа танилцаж, үе тэнгийн ах эгч нараа хэрхэн сурч байгааг харсан хүүхдүүдийн сэтгэлзүй бэлтгэгдэж улмаар сургуульд дасан зохицох нь хялбар болдог.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Энэхүү үйл ажиллагааг нэгдүгээр ангийн сурагчдыг сургуульд бэлтгэх, сургуулийн бэлэн байдлыг хангах сургуулийн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллгааны хэсэг болгон сургуулийн хичээлийн жилийн төлөвлөгөөнд тусган тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай.

37-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Нэгдүгээр ангийн сурагчдад зориулсан номын булан



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Чингэлтэй дүүргийн
37 дугаар бүрэн дунд
сургууль



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Номын санч

ЗОРИЛГО

Нэгдүгээр ангийн сурагчдыг номонд дур сонирхолтой болгох, унших чадварыг сайжруулах



АРГАЗҮЙ

Манай сургууль 6 настай хүүхдийн нас, биеийн онцлогт тохируулан “Номын булан”-г байгуулсан. Энэ булан нь 4 суудалтай, номын 3 тавиур, тоглоомын булантай бөгөөд багш, эцэг эхчүүд ханын том ном, жижиг номыг хийж сангаа баяжуулахад анхаарсан. Анх уншиж сурч буй сурагчдад зориулан тухайн цаг үеийн онцлогийг тусган хүүхдийн унших чадварыг дэмжихэд чиглэсэн номуудыг бүтээдэг. Жишээлбэл: Шинэ жилийн баярыг тохиолдуулан ил захидал ашиглан үзсэн үсгүүдээр нь жижиг ном бүтээлгэх, эцэг эх хүүхэдтэйгээ хамтран уншсан сэдвийн дагуу том ном бүтээж “Номын булан”-даа байрлуулж хүүхдүүдэд ашиглуулдаг. Эцэг эх багш нартай хамтран зурагт бяцхан ном, хялбар унших номыг хийж ашигласан нь хүүхдүүдийн сонирхолд их нийцсэн.

1-р ангийн сурагчид номын сангийн дүрэм журам ойлгомжгүй, хаанаас хэрхэн, ямар ном сонгож уншихаа мэддэггүй. Иймээс тэдэнд зориулж байгуулсан “Номын булан”-гаар хэрхэн үйлчлүүлэх зааврыг таних тэмдгээр дүрслэн хийж өгсөн. Ингэснээр 1-р ангийн сурагчид таних тэмдгээр дамжуулан бусдын тусламж авалгүйгээр бие даан номын сангаар тав тухтай үйлчлүүлэх боломжтой болж өөрчлөгдсөн.

Манай сургууль “Номын булан”-гаар үйлчлүүлэх хуваарь, хүүхдүүдээр ном уншуулах төлөвлөгөөг боловсруулан, мөрдөж ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд “Үлгэр уншиж өгөөч” үлгэрийн цагийг номын санч жилийн ажлын төлөвлөгөөндөө тусган нэгдүгээр ангийн сурагчдад 7 хоног бүр нэг ангид 15-20 минут үлгэрийг хөгжөөнт болон хөдөлгөөнт хэлбэрээр уншиж өгч байна.



ҮР ДҮН

Номын сангийн өрөөнд 6 настай хүүхдүүдэд зориулсан номын буланг нээж өгсөн нь тэдний нас бие, хөгжлийн онцлогт нийцсэн ажил болсон. 6, 7 настай хүүхдүүд номын санд ном уншдаг болсноор номтой нөхөрлөх, унших сонирхлыг улам төрүүлэхэд дөхөм болсон. Бусдын ярих үлгэр, аман яриаг анхааралтай сонсож сурснаар хүүхдийн үгийн нөөц нэмэгдэж, харилцааны чадварт суралцаж байна.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Бага ангийн хүүхдийн сонирхол татахуйц ажиглахад хялбар, ойлгомжтой том, жижиг, ханын номыг хийж номын санд байршуулах нь чухал. Мөн байнга сэлгэж, сэлбэж, баяжуулах, номын санчийн үүрэг оролцоог ажлын байрны тодорхойлолтод нэмэлт оруулах, 1-р АУБ болон номын санчийн хамтын ажиллагааг дэмжих, хамтран ажиллах нөхцлийг сургуулийн захиргааны зүгээс бүрдүүлж өгөх нь чухал.

ШАВЬ ЦОГЦОЛБОР СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Нэгдүгээр ангийн сурагчдад зориулсан хүлээлгийн танхим



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Баянзүрх дүүргийн Шавь цогцолбор сургууль



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Бага ангийн сургалтын менежер

ЗОРИЛГО

Хүүхдүүд сургууль дээрх хичээлийн бус цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэх



АРГАЗҮЙ

“Шавь” цогцолбор сургууль 1-р анги даан авч байгаа багш нар болон эцэг эхийн оролцоотойгоор 6 настай сурагчдад ая тухтай, сонирхлыг нь татахуйц орчныг бий болгох, тэдний хөгжлийг хангах зорилгоор тоглоомын болон амрангаа хөгжих орчныг бий болгосон.

Тухайн орчин нь:

- Тоглоомын булан
- Хэл яриа хөгжүүлэх булан /Үлгэр сонсох, ярих орчин/
- Сэтгэхүй хөгжүүлэх булан
- Байгаль орчныг танин мэдэх булан
- Номын булан
- Замын хөдөлгөөний дүрмийн булан
- Эрүүл мэндийн булан гэсэн хэсгүүдээс бүрдсэн.

Энэ танхимдаа 1-р анги даасан багш нар 3 ээлж болон жижүүрлэж, сурагчдын хичээлийг нь давтуулах, дээрх булангуудад тоглуулах, эцэг эхэд хүлээлгэн өгөх, тэдэнд зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулдаг.



ҮР ДҮН

- Хүүхдүүд шинэ найз нөхөдтэй болох, бусадтай харилцаж сурах, цагийг үр бүтээлтэй ашиглах, өөрийгөө хөгжүүлэх боломж бүрдсэн.
- Багш нарт сурлагын хоцрогдолтой сурагчидтай ганцаарчлан болон бүлгээр ажиллах боломж бүрдсэн.
- Хүүхдүүд замын хөдөлгөөнд оролцох санамж, авах эрүүл зөв дадалд суралцах зэрэг олон талын ач холбогдолтой мэдээллийг эндээс авдаг.
- Эцэг эхээ тохилог тавтай орчинд хүлээх боломжтой болсон.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Энэхүү танхимыг тогтмол цагийн хуваарийн дагуу ажиллуулна. Хариуцан ажиллах багш нарыг томилно.

92-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

“Цүнх” аян



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Сонгинохайрхан дүүргийн
65-р сургууль, Баянзүрх
дүүргийн 92-р сургууль



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Бага ангийн багш нар,
сургуулийн эмч

ЗОРИЛГО

Багш, эцэг эхчүүдэд сурагчийн цүнхний талаар мэдээлэл өгөх, хүүхдэд тохирсон цүнх сонгоход нь туслах



АРГАЗҮЙ

Сургууль “Цүнх” аяны хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд:

- 1 Нэгдүгээр ангийн сурагчдын нас биеийн онцлогт тохирсон цүнхийг хэрхэн сонгох, цүнхний жин хүүхдийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдөг талаар эцэг эх, асран хамгаалагч багш нарт зориулсан зөвлөмж боловсруулж танилцуулах
- 2 Нэгдүгээр ангийн сурагчдын биеийн болон цүнхний жинг зааврын дагуу үзэх
- 3 Нэгдүгээр ангийн сурагчдын хэрэглэх хэрэглэгдэхүүн, сурах бичгийн жинг тооцоолон гаргах
- 4 Сурагчдын биеийн жин, цүнхний жинг харьцуулан цүнхний байх ёстой жинг тооцон гаргах (стандартын дагуу цүнхний жин сурагчийн биеийн жингийн 10-15%-тай тэнцэхүйц байна).
- 5 Хичээлийн хуваарийг хэрэглэх хэрэглэгдэхүүн, сурах бичгийн жинг харгалзан төлөвлөх
- 6 Сурагчдын үдийн цай, биеийн тамирын хувцас зэргийг анги танхимд хадгалах, байнга хэрэглэдэг хэрэглэгдэхүүн, сурах бичгийг 2 ээлжийн болгох
- 7 Ангийн эцэг эхийн зөвлөл анги удирдсан багш хамтран цүнхний жинг стандарт хэмжээнд байлгах талаар арга хэмжээг зохион байгуулах
- 8 Цүнхний жингийн судалгааг тогтмол авч үр дүнг тооцон, хэлэлцэх

1-р ангийн сурагчдын цүнхний жингийн судалгаа
/469 сурагч, 1 сарын дараа/



6 НАСТАЙ ХҮҮХДИЙН
ЦҮНХ **2 КГ**-ААС ХЭТРЭХГҮЙ
ЖИНТЭЙ БАЙХ НЬ
ЗОХИМЖТОЙ.



Учир нь хүнд цүнх хүүхдийн бие бялдрын хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна цаашид нурууны өвчлөлд өртөх магадлал өндөр байдаг.



ҮР ДҮН

- Хүнд цүнх үүрч явах нь хүүхдэд ямар хор уршигтай талаар багш, сурагчид, эцэг эх, асран хамгаалагчид мэдлэг мэдээлэлтэй боллоо.
- Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ цүнхний жинг стандарт хэмжээнд нь байлгах талаар анхаардаг боллоо. Тухайлбал, эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ “Үдийн цай”-ны аягыг сонгохдоо жинг харгалзан үзэж, эрүүл ахуйн шаардлага хангасан хөнгөн аяга сонгон хэрэглүүлж байна.
- Аяныг хэрэгжүүлснээс хойш нэг сарын дараа цүнхний жингийн илүүдэлтэй сурагчдын тоо буурсан байв.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Сургуулийн хэмжээнд “Цүнх” аяныг 1 дүгээр анги төдийгүй 2-5 дугаар ангийн сурагчдын хэмжээнд явуулах нь зөв зүйтэй гэж үзсэн тул сургуулийн нэгдсэн төлөвлөгөөнд оруулан уламжлалт ажил болгон хэрэгжүүлнэ.

39-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Уншлагын хөзөр-Ширээний тоглоом



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Чингэлтэй дүүргийн 39-р бүрэн дунд сургуулийн бага ангийн багш Ш.Баасансүрэн



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Анги удирдсан багш

ЗОРИЛГО

Тоглоомын аргаар хүүхдийн үсэг, үе, үг нүдлэх, уншиж сурах, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, хүүхдийн суралцах чадварыг дээшлүүлэхэд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх



АРГАЗҮЙ

6 настай хүүхдүүд анх сургуульд элссэнээр тоглоомын үйлээс суралцах үйлд шилжиж шинэ харилцаа, шинэ орчин, шинэ дэглэмд орж эхэлдэг. Тиймээс 6 настай хүүхдийн тоглонгоо суралцдаг онцлогт тулгуурлан суралцах арга барилыг ангийн сурагчиддаа эзэмшүүлэхийг зорьж ажиллалаа. ЯХИС-аас боловсруулсан модулийн хүрээнд тоглоомын олон аргазүйг хичээл сургалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан ба үүнээс “Уншлагын хөзөр- Ширээний тоглоом” аргыг сургалтад хэрхэн ашигладгаа хуваалцъя.

Хэрэглэгдэхүүн бэлтгэх:

- 1 Ангийн эцэг эхчүүд хамтран бүх үсэг, үеийн багцыг компьютерт шивж хэвлэн хөзрийн хэмжээтэй хайчилж хөзрийн ард талд нааж бэлтгэнэ.

Уншлагын хөзрийг ашиглах үе шат:

- 1 Хүүхдүүд хосоороо тоглоно. Хөзрөө холиод тус бүр тав таван хөзөр аваад үлдсэн хөзрийг доош харуулан газарт давхарлан тавина.
- 2 1-р тоглогч өөрийн хөзрөөс нэгийг авч 2-р тоглогчид уншуулан дахин нэгийг газраас сугалж авна.
- 3 2-р тоглогч 1-р тоглогчийн өгсөн хөзрийг уншина. Хэрвээ уншиж чадаагүй бол тэр хөзрөө гартаа авна. Харин уншиж чадсан тохиолдолд хөзрөө доош харуулж ялгаж тавина.
- 4 Дээрх дарааллаар бие биедээ хөзөр өгч уншуулна.
- 5 Хамгийн түрүүнд гартаа хөзөргүй үлдсэн тоглогч нь ялагч болно.

Энэхүү аргазүйг ангийн багш хичээлийн завсарлагаанаар болон хичээлийн дараа эцэг эхээ хүлээж байх зуур хүүхдүүдээр тоглуулснаар хүүхдүүд үсэг, үе, үгийг унших, нүдлэх, бичих чадвараа хөгжүүлдэг. Ангийн үүдэнд коридорын хананд тус хөзрийг байрлуулан хүүхдүүд чөлөөтэй авч тоглох боломж нөхцөлийг бүрдүүлсэн.

Сурагчид тоглоомын ялагч болохын тулд үсэг, үе, үгийг нүдлэх, уншиж сурахад ихээхэн хичээл зүтгэл гаргадгаас гадна бие биеэ урамшуулж дэмжиж харилцан бие биедээ тусалдаг. Энэ аргыг илүү гүнзгийрүүлэн үсэг, үеүүдийг ашиглан үг, өгүүлбэр эвлүүлж тоглуулах боломжтой.

Эцэг эхчүүд гэртээ хүүхдэдээ **тодорхой хугацаа өгч** тоглуулдаг. Ингэснээр эхний үед 2 минутанд 10 карт уншиж байсан бол 5 хоногийн дараа 19 карт унших зэргээр хүүхдийн унших хурд нэмэгдэж байсан.

Хоёр хүүхэд тоглож байгаа тохиолдолд түвшингээр ойролцоо хүүхдүүдийг хооронд тоглуулах хэрэгтэй. Хүүхэд хэрвээ олон удаа дараалж хожигдвол хүүхдийн урам хугарч болзошгүй гэдгийг багш эцэг эхчүүд анхаарах хэрэгтэй.



ҮР ДҮН

- Сурагчдын цээжээр бичих, нүдлэн тогтоох, сэтгэн бодох, унших хурд нэмэгддэг.
- Хосоор болон багаар ажиллах явцад сурагчид бие биедээ туслах, зааж хэлж өгөх бусадтай саналаа солилцох, бусдыгаа сонсох зэрэг харилцааны хөгжилд ахиц ажиглагдаж байсан.
- Хүүхэд тоглонгоо сурч болдог юм байна гэдгийг эцэг эхчүүд ойлгож улмаар хүүхэдтэйгээ ажиллах чадвар нь тодорхой хэмжээгээр нэмэгдсэн.
- Эцэг эхчүүд гэртээ хүүхэдтэйгээ тоглонгоо сургаж хөгжүүлж байгаа учраас хүүхэд хичээл, даалгавар гэж халшрахгүй, харин ээж аавтайгаа хамт тоглоно гэсэн үүднээс сэтгэлзүйн эерэг хандлагатай байсан.
- Эцэг эх, асран хамгаалагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэн ажилласнаар багш бидний ажлын ачаалал багасч, эцэг эхчүүд сургалтын бүх л үйл ажиллагаанд жигд оролцдог болсон.
- Сурагчдын сурах, тогтоох, нүдлэх унших чадвар хөгжихийн хэрээр тэдний унших хүсэл эрмэлзлэл, сонирхол улам нэмэгдсэн.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Багш эцэг эхийн сургалтаараа энэ аргазүйг эзэмшүүлж байх, 1-р анги анх удаа даан ажиллах багшид тухайлан энэ аргазүйг зааж сургах нь цаашид энэ аргазүйг хэрэглэж дадахад тустай.

79-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Нэгдүгээр ангийн сурагчдаар “Жижиг ном” хийлгэх



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

БЗД-ийн 79-р бүрэн дунд сургуулийн бага ангийн багш Ц.Золзаяа



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Анги удирдсан багш

ЗОРИЛГО

Нэгдүгээр ангийн сурагчдын сэтгэн бодох, ярих, бичих, зурах, үг хэллэг сонгох, бусдаас суралцах, өөртөө итгэлтэй болох, дотоод сэтгэлээ нээн хөгжүүлэхэд туслах жижиг ном хийлгэх



АРГАЗҮЙ

Нэгдүгээр ангийн Монгол хэлний хичээлээр нэгдүгээр ангийн сурагчдаар тухайн үзэж буй сэдвийн хүрээнд “Жижиг ном” бүтээлгэн ажилласан нь ихээхэн үр дүнтэй байсан. Тус номыг дараах хэлбэрүүдээр бүтээлгэсэн. Үүнд:

- Зурагт хайчилбар ашиглах
- Зүйр цэцэн үг зохиох
- Наамал хийх
- Үгийн утгын тайлбар хийх


Зурагт хайчилбар ашиглан жижиг ном бүтээх аргачлалыг энд дэлгэрүүлэн танилцуулъя. Үйл ажиллагааны дараалал:

- 1 Үйл явдлыг илэрхийлсэн зургуудыг сурагч бүрт тарааж өгнө.
- 2 Жижиг номын хуудсуудыг бэлтгэнэ.
- 3 Багш зургууд дахь үйл явдлын дарааллыг хүүхдүүдээр хэлүүлэхийн тулд асуулт асууж ярилцана. Жишээ нь:
 - а. Болд эхлээд юу хийсэн бэ?
 - б. Дараа нь хаашаа явсан бэ?
 - в. Болд хэнтэй ярилцсан бэ? гэх мэт
- 4 Жижиг номын нүүр хэсгийг чимэглэнэ.
- 5 2-р нүүрнээс эхлэн зургийг дарааллын дагуу наана.
- 6 Зураг бүрт харуулсан үйл явдлын талаар сурагчид өөрсдийн үгээр өгүүлбэр зохион бичнэ. Мөн үг бичих, зураг нөхөх, сэдвийн нэр өгөх зэрэг хувилбараар ажиллуулж болно.

Ангид хүүхдүүд хамтран жижиг ном хийх үйл ажиллагаа нь сурагчдад бусдын хийсэн бүтээлд үнэлэлт өгөх, өөрийн санаагаа илэрхийлэх, бусдын хийсэн бүтээлээс санаа авч засан сайжруулах үг хэллэгийг сонгох, урнаар сэтгэх, утгын найруулгыг засах, ургуулан төсөөлөн бичих чадваруудыг олгодог.

Анхаарах зүйл

Жижиг ном бүтээх зургуудыг сонгохдоо хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон, сонирхлыг нь татахуйц, тэдний бүтээл хийх хүсэл эрмэлзлийг төрүүлэхүйц, үйл явдлын өгүүлэмж ойлгомжтой, харагдахуйц байх шаардлагатайг багш, эцэг эхийн зүгээс анхаарах хэрэгтэй.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Жижиг номоор ангийн номын санг баяжуулах, дараагийн ангийн дүү нартаа шилжүүлэн хэрэглэх зэргээр ашиглах бололцоотой. Хийсэн номынхоо үйл явдлыг дүрээр баяжуулан тоглолт хийх, шүлэг зохиох, зүйр цэцэн үг чээжлэх зэргээр ажиллах боломжтой. Мөн багш анги дэвших тусам хувирган ашиглаж болно.



ҮР ДҮН

Энэ аргагүй нь доорх чадваруудыг хөгжүүлэхэд ач холбогдолтой болох ажиглагдсан. Үүнд:

- 1 Номын нүүр хийснээр хүүхдийн хээ, угалз, чимэглэл зураг хийх бүтээлч чадвар
- 2 Зургийн үйл явдлыг хараад ойлгох, таамаглал дэвшүүлэх, логик дарааллыг олох, зөв цэгцтэй бичиж, ярих чадвар
- 3 Хүүхдүүд ном бүтээхдээ хэвшмэл нэг загварт баригдахгүйгээр мэдлэгээ ашиглан олон талаас нь эргэцүүлэн бодож сурах, өгүүлбэрийг хувирган өөрчлөн бичих чадвар
- 4 Үзсэн, харсан, сонирхол татсан байгалийн үзэсгэлэнт газар, аялал зугаалгынхаа тухай хүүхдүүд зурж, ном хийх нь тэдний өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд тустай байлаа.

Түүнчлэн эцэг эхчүүд хүүхдийнхээ хийж байгаа зүйлийг дэмжиж урмын үгээр магтан сайшаах, хүүхэд өөртөө итгэлтэй байж, өөрийн бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эргэлзээтэй зүйлээ асуух, бусадтай санаа бодол нэгдэх, бусдаас суралцах зэрэг аливаад бүтээлч хандах хандлагыг бий болгох чухал ач холбогдолтой байдаг.

ШАВЬ ЦОГЦОЛБОР СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

“Миний зугаатай амралт”
зурагт даалгаврыг
хэрэгжүүлсэн туршлага



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Баянзүрх дүүргийн Шавь
цогцолбор сургуулийн 2e
ангийн багш Ж.Нарантуяа



ХАРИУЦАХ АЖИЛТАН

1-р ангийн багш

ЗОРИЛГО

1-р ангийн сурагчдаар санаа бодлоо цэгцтэй бичиж тэмдэглэж сурах, өөрийгөө илэрхийлэх, өөрт тохиолдсон зүйлээ бусадтай хуваалцах чадварт сургах зорилгоор зурагт даалгавар бүтээлгэх



АРГАЗҮЙ

“Эцэг эх- багштай харилцах дэвтэр”-ийг хөтөлж ажиллах хугацаандаа “**Миний зугаатай амралт**” сэдвээр өвөл, зуны амралтаа хэрхэн өнгөрүүлсэн талаар ангийн сурагчдаараа зургийн цомог хийж ирэх даалгавар өгч ажиллалаа.

Хүүхэд бүр өөрийн сонирхсон хэлбэр загвар, материалаар эцэг эхтэйгээ хамтран зургийн цомгоо хийж түүнийгээ ангийхандаа танилцуулан ярьж өгдөг. Хүүхдүүд цагаан толгойн үсгээ үзэж дуусаагүй байгаа үед эцэг эхчүүд холбогдох тайлбарыг бичиж өгнө.

Амралтаа өнгөрөөсөн газар, шинээр хийж сурсан зүйлс, шинэ найзууд болон цагийг хамт зугаатай өнгөрүүлсэн эмээ, өвөө, эгч ах дүү, хамаатан садан зэрэг хүмүүсийнхээ талаар хуваалцах сонин сайхан хүүхдэд их хуримтлагддаг. Сонирхолтой цомог хийхийн тулд эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ хамт очиж үзээгүй газраар аялах, шинэ зүйл тайлбарлаж өгөх, шинээр ямар нэг үйлд сургах (шатар тоглох, цанаар гулгах гэх мэт) зэргээр хүүхдэдээ анхаарал тавих нь эрс сайжирч байгаа нь ажиглагдаж байсан.

Тус зургийн цомгийг ангийн номын санд байрлуулснаар завсарлагааны цагаар хүүхдүүд тэдгээрийг үзэж сонирхон тайлбарыг уншиж, хоорондоо ярилцан мэдээлэл солилцож, шинээр сурсан зүйлээ бие биендээ зааж өгдөг.



✓ ҮР ДҮН

Энэхүү даалгаврыг тогтмол хийлгэж заншсанаар хүүхдүүдэд олон үр дүн гарч байна. Тухайлбал:

- Хүүхдүүд үзсэн харсан зүйлээ цэгцтэй бичиж сурдаг
- Танин мэдэхүйн мэдлэгээ нэмэгдүүлдэг.
- Хүүхэд өөртөө итгэлтэйгээр уран тод ярих, өөрийгөө илэрхийлэх чадвар сайжирдаг.
- Бусадтайгаа санал бодлоо хуваалцах, бусдыг сонсох чадвар сайжирсан.
- Эцэг эхчүүд хүүхдийнхээ үгийг сонсож даалгаврыг сайн биелүүлэхийн тулд гэр бүлдээ цаг зав гаргах нь өмнөх ангиудтай харьцуулахад маш сайн болсон
- Эцэг эхийн хурал дээр хүүхдүүдээр зургийн цомгийг танилцуулан яриулахад эцэг эхчүүд хүүхдүүдээрээ бахархах, хүүхдийнхээ төлөө илүү ихийг хийх хүсэл сонирхолтой болж байгаа нь харагдаж байсан.

📖 ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Хүүхдийг анги дэвших тусам бусад хичээлийн агуулгатай холбож зургийн цомгийг агуулгыг баяжуулан хэрэгжүүлэх боломжтой юм.

117-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Тоглоомын аргаар нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дээшлүүлэх



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Чингэлтэй дүүргийн
117 дугаар бүрэн дунд
сургуулийн бага ангийн
багш М.Ариунзаяа



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Анги удирдсан багш

ЗОРИЛГО

“Би үг бодож оллоо” тоглоомоор дамжуулан хүүхдийн авиаг ялган сонсох, үг таах, таавар таах, санаа бодлоо илэрхийлэх чадварыг хөгжүүлэх



АРГАЗҮЙ

Нэгдүгээр ангийн сурагчдын авиаг ялган сонсох, үг таах, таавар таах, санаа бодлоо илэрхийлэх чадварыг сайжруулах зорилгоор “Би үг бодож оллоо” тоглоомын аргазүйг хэрэгжүүлэн ажилласан. Эдгээр тоглоомыг ангийн эцэг эхчүүдийн туслалцаатайгаар хамтран хийсэн.

Хэрэглэгдэхүүн бэлтгэх:

- 1 Ангийн эцэг эхчүүдтэй хамтран бүх үсэг, үе, үгийн багцыг компьютерт шивж хэвлэн хөзрийн хэмжээтэй хайчилж хөзрийн ар талд нааж бэлтгэнэ.
- 2 Мөн зурагтай номны хайчилбар бэлтгэн ламинатордана.

“Би үг бодож оллоо” тоглоомыг ашиглах үе шат:

- 1 **1-р багц:** Зурган багц.
Үүнийг гурван үе шаттай хэрэглэнэ.
Хүүхэд зургийг ажиглан зурагт үзүүлсэн зүйлсийг өөрийн үгээр нэрлэх, өгүүлбэр зохиох
 - Цуврал зургийн үйл явдлыг өөрийн үгээр ярих, цааш нь дэлгэрүүлж ярих
 - Хайчилбарт зургийг эвлүүлэх, өгүүлбэр зохиох
- 2 **2-р багц:** Үг бодож оллоо багц.
Энэ багцыг хоёр үе шаттай хэрэглэнэ.
 - Багш хүүхдүүдэд нэг үсэг хэлж тухайн үсгээр эхэлсэн үг бодож олоорой гэж хэлнэ. Жишээ нь: **М** үсгээр эхэлсэн үг хэлээрэй гэхэд хүүхдүүд машин, манжин гэх мэт хэлнэ.
 - Багш нэг үсэг хэлж, тухайн үгийг тайлбарлаж хүүхдүүдээр таалгана. Жишээ нь: **М**... үсгээр эхэлсэн, тэр амьтан 4 хөлтэй, урт сахалтай, хүнд амархан дасдаг, гэрийн тэжээвэр амьтан. Ямар амьтан бэ? (муур)
- 3 **3-р багц:** Үгэн багц.
Үүнийг багш хоёр үе шатаар хэрэглэж болно. Энэ тоглоомыг хүүхдүүд ганцаараа, хосоороо эсвэл багаараа тоглож болно.

- Багш олон үг тарааж өгөөд тараасан үгнүүдээс үг олуулна. Хичээлийн цагаас хамааран олон үг олуулж болох бөгөөд хэн хамгийн олон үг олсон нь хожно.
- Үсэг нөхөж үг үүсгэх /ц...ц...г - цэцэг гэх мэт/

4 4-р багц: Үсгэн багц.

Мөн хоёр үе шаттайгаар хэрэглэх боломжтой. Энэ тоглоомыг үсэг нүдэлж байх үед тоглуулбал тохиромжтой.

- “Үсэг хайж олоорой” тоглоом тоглуулна. Хэдэн ч хүүхэд тоглож болох бөгөөд олон үсгүүдээс багш нэг үсэг нэрлэж хүүхдүүдээр олуулах бөгөөд хэн олон үсэг олсон нь хожно. Дараагийн үсгийг хүүхдээр хэлүүлж болно.

- Үе хайж олох, үеэр үг бүтээж тоглох зэрэг олон янзаар хэрэглэж болно

5 5-р багц: Таавар таалгах багц

- Хүүхдүүд хосоороо тоглоно. Нэг нь таавар уншиж өгч, нөгөө нь таана. Тааж чадахгүй тохиолдолд нэмэлт тайлбар хэлж өгч болохоор бэлтгэнэ.

6 6-р багц: Үеийн багц

- Хүүхэд хэлэхэд хүндрэлтэй байгаа үгийг нь үеэр таслан хэлүүлнэ. (ман+жин гэх мэт) Хэлж чадахгүй бол багш засаж хэлж өгнө.

Энэхүү аргазүйг ангийн багш хичээлийн үед, завсарлагаанаар болон хичээлийн дараа эцэг эх нь ирж авах хооронд тоглуулах, ангийн бүтээлийн тавиур дээр байрлуулан хүүхдүүд чөлөөтэй авч тоглох боломжийг бүрдүүлсэн.

Мөн эцэг эхчүүдэд энэ аргуудыг зааж гэртээ хүүхэдтэйгээ тоглох боломжийг бүрдүүлснээр эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэдтэй нь хамт хөгжүүлсэн.



ҮР ДҮН

Энэ аргазүйг тогтмол хэрэглэснээр хүүхдүүд үсэг, үе, үгийг хурдан нүдэлж унших хурд нь сайжирсан.

“Би үг бодож оллоо” тоглоомыг зурган багцаар тоглосны дараа үгэн багц тоглоом руу шилжих зарчмаар тоглуулснаар хүүхдийн хувьд тоглоом тоглохоос гадна ярих, сэтгэх, таавар таах, өөрийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэхээс гадна, шүлэг амархан цээжилдэг болсон. Ингэснээр хүүхдийн ичимхий бүрэг байдал багасч, өөртөө итгэлтэй байдал нэмэгдсэн.

Эцэг эхчүүдийн хувьд гарын доорх материал ашиглан хялбар аргаар дээрх багцуудыг хийж бүтээлч байдлаар хүүхдээ хөгжүүлж болдгийг ойлгосон.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Жил бүрийн нэгдүгээр ангийн секцийн багш нар тус багцуудыг цаашид 2, 3-р ангийн хичээлийн агуулгад тохируулан сэдвийг өөрчлөн хэрэглэх боломжтой юм.



105-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Нэгдүгээр ангийн сурагчдаар шүлэг, оньсого чээжлүүлэх



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

СХД-ийн 105-р бүрэн дунд сургуулийн 1ж ангийн багш Ж.Болорзаяа



ХАРИУЦАХ АЖИЛТАН

1-р ангийн багш

ЗОРИЛГО

Нэгдүгээр ангийн сурагчдад шүлэг, дуу, оньсого, зүйр цэцэн үгийг хурдан чээжлүүлж сургах замаар хараа, хөдөлгөөний ой тогтоолтыг сайжруулах



АРГАЗҮЙ

Нэгдүгээр ангийн хүүхдүүдэд шүлэг, дуу, оньсого, зүйр цэцэн үг, цээжлүүлэхдээ тухайн хүүхдийнхээ харааны, сонсголын, хөдөлгөөний ой тогтоолтын аль давуу байгаа чадварыг ашиглан цээжлүүлэх аргазүйг хэрэгжүүлж ажиллалаа. Энэхүү аргазүй нь сурагчид аливаа зүйлсийг нэг талаас нь хий хоосон цээжлэх биш, олон талаас бодитоор дүрслэн харах, сонсох, хүртэх, хөдөлгөөн хийх зэрэг бүхий л талуудын чадваруудыг хөгжүүлсэн.

Намар 9-р сарын эхээр “Манай гэр бүл” гэдэг шүлгийг сонгон цээжлүүлсэн. Зургаан настай хүүхдүүд анх сургуульд орж шинэ орчин, шинэ харилцаа үүссэнээр айж сандрах, эмээх гэх мэт сургуулийн орчинд дасан зохицоход олон бэрхшээлүүдтэй тулгардаг. Энэ үед хайртай гэр бүлийнх нь гишүүдийг оролцуулсан шүлэг зааснаар илүү хурдан хүлээж авч, хурдан дасан зохицож, нээлттэй болж чаддаг.

Хүүхдүүд “Аавын гар” “Гурван тоорой” гэх мэт шүлгүүдийг уран тод уншихын зэрэгцээ тухайн шүлгийн утга санаанд тохирсон хөдөлгөөн хийхийн зэрэгцээ багш самбарт дагуулан зурж харааны ойг нь давхар хөгжүүлэх боломжтой. Жишээ нь:

“Манай гэр бүл” шүлэг

Өвөө минь гэртээ цэлмэг тэнгэр - Хоёр гараараа тэнгэр уруу заана.

Эмээ минь гэртээ уудам тал - Хоёр гараараа газар уруу заана.

Аав минь гэртээ ханагар уул - Хоёр гараараа нийлүүлж уулыг дүрслэнэ.

Ээж минь гэртээ алтан нар - Хоёр гараараа нарны цацраг дүрсэлж зөрүүлнэ.

Ах минь гэртээ ургаа хад - Нэг гараа биеийнхээ урдуур тохойгоороо нугалж нөгөө гарныхаа тохойнд хүргээд, нөгөө гараа тохойгоороо дээш нугалж бугуйгаараа эргүүлнэ.

Эгч минь гэртээ гоёхон цэцэг - Хоёр гараа биеийнхээ хажуугаар дээрээс доош чиглэлд бугуйгаараа эргүүлэн сууна.

Дүү минь гэртээ бөжин туулай - Толгой дээрээ хоёр гараа бугуйгаараа урагшаа хойшоо туулайны чих мэт болгоно.

Би өөрөө (охид - ганган эрвээхий) - Хоёр гараа дэвнэ; (хөвгүүд - барын бамбар) - Хоёр гараа барын савруу шиг болгон аррррр гэж дуугарна.

Шүлгийг цээжлүүлсний дараа утга санаанд тохируулан хүүхдүүдээр зураг зуруулж, өөрсдөөр нь тайлбарлуулан ярилцдаг. Эцэг эхчүүддээ бас хэт их ачаалал үүсгэхгүйгээр долоо хоногт 2-3 шүлэг, зүйр цэцэн үг, оньсого зэргийг ээлжлэн урьдчилан өгч явуулах ба хэрхэн ямар аргаар цээжлүүлэх талаар багш зөвлөгөө өгдөг.



ҮР ДҮН

Энэ аргазүйгээр маш богино хугацаанд ангийн бүх сурагчид олон шүлгийг уран тод, хөдөлгөөнтэйгээр хурдан цээжилж сурсан ба хичээлийн дундуур болон



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Багш нар эцэг эхийн сар бүрийн сургалтаар дамжуулан дээрх аргазүйн зөвлөгөөг тухай бүрд нь эцэг эхчүүддээ өгч хамтран ажиллах нь зүйтэй.



65-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Эцэг эхийн хурал болон ганцаарчилсан уулзалтыг үр дүнтэй зохион байгуулах



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Сонгинохайрхан дүүргийн 67-р бүрэн дунд сургуулийн бага ангийн багш Г.Ариунаа



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Анги удирдсан багш

ЗОРИЛГО

Эцэг эхийн хурлыг үр дүнтэй зохион байгуулж, хамтын ажиллагааг идэвхжүүлэх




АРГАЗҮЙ

Ангийн нийт эцэг эхийн хурал болон эцэг эхтэй ганцаарчилсан уулзалтыг сонирхолтой арга хэлбэрээр үр өгөөжтэй зохион байгуулах нь эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, эцэг эх, хүүхдийг хамтад нь хөгжүүлэх, идэвхжүүлэх, аливаа асуудалд хандах хандлагыг нь өөрчлөхөд ихээхэн үр дүнтэй байлаа.

Эцэг эхийн хурлыг дараах үе шатаар зохион байгуулах аргазүйг танилцуулж байна. Үүнд:

- 1 **Эцэг эхийн хурлын урилга тараах:** Урилгыг олон хэлбэрээр хийж болно. Урилган дээр тухайн хуралд ирэх эцэг эхийн нэрийг заавал бичих ба ангийн сурагчдаар дамжуулан илгээнэ.




- 2 **Сайхан үг:** Хүн бүр чин сэтгэлээсээ хэлсэн сайхан үгэнд дуртай байдаг. Багш эцэг эхчүүдэд урам өгч, тэднийг сайшаан магтаж байх хэрэгтэй (Жишээ 1). Мөн эцэг эхчүүдийг өөрийнхөө талаар өөдрөг, эерэг бодолтой явахыг дэмжиж байх нь чухал (Жишээ 2).
Эцэг эхийн хурлын эхэнд багш эцэг эхчүүдэд нарийн цавуутай цаас тарааж өгч цаасан дээрээ бичсэн сэтгэлийн сайхан үгийг хэлж, нарны цацраг хэлбэрээр нааж өгнө.

Жишээ 1: Зураг хийж өгөх


Нарны хэлбэрт оруулж наасны учир нь ангийн хурлын ирцийг илэрхийлж болно.

Жишээ 2: Эцэг эхчүүд дараах үгийг хэлэхдээ “Толинд” харж хэлнэ.

Би энэ хорвоогийн хамгийн сайхан..... юм. (аав, ээж, хань, найз... гэх мэт)



3 Ширээ засалт ба суудал хуваарилалт: Уламжлалт байдлыг эвдэн ангийн ширээгээ олон төрлийн хэлбэрээр засаж хурлаа зохион явуулах нь эцэг эхэд сонирхолтой байдаг. Хурлын ширээг засахдаа эцэг эхчүүд өөд өөдөөсөө харж ярилцах боломжтой, хүн бүрийн оролцоог дэмжсэн байдлаар засахад анхаарах хэрэгтэй. Доорх зургуудаас санаа авч болно.



Эцэг эхчүүдээ баг болгон хувааж суулгаж болно.

Үүнд:

- Ажил мэргэжлээр
- Сонирхлоор
- Санал асуулгаар
- Ангид орж ирсэн дарааллаар гэх мэт.

4 Сурган хүмүүжүүлэх хичээл: Сургууль болон ангид ямар үйл ажиллагаа явуулсан тухай ярилцана. Дараа нь эцэг эхчүүдэд сурган хүмүүжүүлэх зөвлөгөө өгнө. Жишээ нь: Залуу эцэг эхчүүд, мөн анхны хүүхэд нь сургуульд орж байгаа эцэг эхчүүдэд зөвлөх. Сургуульд орж байгаа хүүхдийн буюу 6 настны онцлог, сургуульд дасан зохицох, мөн судлах гэж буй хичээлээр нь урьдчилж аргазүйн зөвлөгөө өгөх гэх мэт.

Тогтмол өдөр: Эцэг эхийн хурлыг тодорхой тогтсон өдөр явуулна. Жишээ нь: Манай нэгдүгээр ангийн багш нар 14 хоногт нэг удаа буюу **Пүрэв гарагт** тогтмол зохион байгуулдаг. Энэ нь эцэг эхэд өөрийн ажил төрлөө зохицуулан хуралд ирж оролцох гол зохицуулалт болдог. Эцэг эхийн хурлыг явуулахдаа эцэг эхийн тав тухтай орчинг бүрдүүлж ажиллах, тэдэнд таатай сэтгэгдэл төрүүлэхийн тулд “Кофе юу? Цай юу?” хэмээх асуултаар эхэлдэг.



Ганцаарчилсан уулзалт: Ангийн багш шаардлагатай тохиолдолд эцэг эхтэй “Ганцаарчилсан уулзалт” хийнэ. Хүүхэд нь сурлагын хоцрогдолтой, хүмүүжил төлөвшил нь анхаарал татсан, сургуульд дасан зохицох, сурах бэрхшээлтэй байгаа бол сурагчдын эцэг эхтэй ганцаарчлан уулзаж болно. Ингэхдээ тодорхой цаг товлон эцэг эхчүүдэд урьдчилан мэдэгдэхээс гадна багш тухайн уулзалтдаа сайтар бэлтгэх хэрэгтэй.

Уулзалтын эхэнд хүүхдийн сайн талыг ярилцана. Дараа нь хүүхдэд анхаарах асуудлыг онцлон ярилцаж, шалтгааныг тодруулах мөн эцэг эхийн эргэлзэж асуусан зүйлд сэтгэлзүйн болон сурган хүмүүжүүлэх зөвлөгөө өгдөг. Ингэснээр эцэг эх, хүүхдийн хоорондын харилцаа, багш- эцэг эхийн хамтын үйл ажиллагаанд сайнаар нөлөөлж, хүүхдийн сургуульд дасан зохицох, суралцах чадвар дадал төлөвшилд сайн дэмжлэг болдог.



ҮР ДҮН

Анги удирдсан багш ийм хэлбэрээр эцэг эхтэй хурал, уулзалтыг зохион байгуулснаар дараах эерэг өөрчлөлтүүд гарсан.

- Эцэг эхийн хандлага өөрчлөгдөн сайжирсан
- Хурлын ирц 95-100% болсон
- Бие биенээсээ суралцсан
- Багшийн ажлыг үнэлдэг болсон
- Хүүхдийнхээ гэрийн даалгавар хийхэд туслах аргад суралцсан
- Ангид зохион байгуулах ажлуудын ихэнх хувийг эцэг эхчүүд санаачилдаг болсон
- Багштай хамтран ажиллах хүсэлтэй бөгөөд “Хүүхэд” гэсэн харах зүг нэг болсон



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Багш дээрх аргазүйг бүх ангид хэрэгжүүлэх боломжтой ба бусад багш нарт туршлагаа хуваалцан дэлгэрүүлж ажилладаг.

72-Р СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Ангийн эцэг эхийн зөвлөлийг байгуулах



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

Чингэлтэй дүүргийн 72 дугаар бүрэн дунд сургуулийн бага ангийн Б.Бадамхатан



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Анги удирдсан багш

ЗОРИЛГО

Эцэг эхийн зөвлөлийг хүүхдийн хөгжлийн дэмжигч байдлаар зохион байгуулах



АРГАЗҮЙ

Сурагчдыг зөв дадал хэвшилд сургах, сурлагын чанар, хүмүүжил, төлөвшилд сайнаар нөлөөлөхөд дан ганц багшийн үйл ажиллагаанаас гадна эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо маш чухал юм. Иймээс эцэг эх, асран хамгаалагчдыг багшид чин сэтгэлээсээ тусалдаг, хүүхдийнхээ төлөө анхаарал хандуулж цаг зав гаргадаг болгоход энэхүү аргазүй тус дэм болно.

Хамгийн эхний эцэг эхийн хурлаар багш өөрийгөө танилцуулах, эцэг эхчүүдтэй танилцах, тэднийг хооронд нь танилцуулж эерэг дотно уур амьсгал төрүүлэхийн тулд “Кофе юу?, цай юу?” нэртэй танилцах үйл ажиллагаа зохион явуулсан. Хурлын өмнө багш ангийн ширээг эцэг эхчүүд хоорондоо ярилцах боломжтой, нээлттэй харилцааг дэмжсэн тав тухтай байдлаар засаж бэлтгэсэн байна.

Эцэг эхчүүд өөрсдийн мэргэжил, чадвар, сонирхол, нөөц боломж дээр үндэслэн (1) Оролцоо, (2) Авьяас, (3) Ахиц амжилт, (4) Төлөвшил, (5) Эрүүл мэнд гэсэн таван багт өөрийн сонирхолоор хуваагдаж сууна. Эрүүл мэндийн чиглэлийн байгууллагад ажилладаг эцэг эхчүүд “Эрүүл мэнд” багт, урлагийн салбарт ажилладаг, спортоор хичээллэдэг эцэг эхчүүд “Авьяас” багт гэх мэтээр хувиарлагдах ба баг бүр дундаасаа ахлагчаа сонгоно. Зарим эцэг эхчүүд аль багт орохоо мэдэхгүй байсан тул багш чиглүүлэн ажилласан.

Эдгээр сонгогдсон 5 багийн ахлагч нь ангийн эцэг эхийн зөвлөлийн гишүүнээр ажилладаг.

Үүний дараа эцэг эхчүүд бүр өөрийн хамгийн сайн чаддаг зүйлээ гарын хурууны хэлбэрт оруулан бичиж **“Ангийн баруун гарын баталгаа булан”**-д байршуулж багаараа ярилцан ЭЭЗ-ийн ажлын төлөвлөгөөгөө гаргасан. Эдгээр үйл ажиллагаанууд нь хүүхдийн хөгжил төлөвшил, суралцах чадварын дээшлүүлэхэд чиглэсэн ажлууд байхыг багш анхааруулна.

- “Ахиц амжилт” багийн эцэг эхчүүд сурагчдын сургалтын үйл ажиллагааг дэмжин, сурлагын чадварт ахиц гаргахад тусалж ажилласан.
- “Оролцоо” багийн эцэг эхчүүд хичээлээс гадуурх үйл ажиллагаанд сурагчдыг татан оролцуулахад дэмжин ажилласан.
- “Авьяас” багийн эцэг эхчүүд сурагчдын авьяас, сонирхлыг судлан хөгжүүлэхэд дэмжин ажилласан.
- “Эрүүл мэнд” багийн эцэг эхчүүд сурагчдыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болгоход дэмжиж ажилласан.
- “Төлөвшил” багийн эцэг эхчүүд сургууль ба ангийн дэгийг мөрдөн хэрэгжүүлэхэд тусалж дэмжин ажилласан.

Эцэг эх бүрийг сургууль, анги, эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд хэрхэн оролцож байгааг үнэлэх, урамшуулах зорилгоор “Цэцэг ургуулах” самбарыг ажиллуулсан нь их үр дүнтэй байсан. Хүүхэд бүрийн нэрээр өнгийн цаасаар ваартай цэцэг бүтээж ангид байршуулах ба эцэг эх үйл ажиллагаанд оролцох бүрт 1 навч нэмж наадаг. Улирлын эцэст самбарт наасан навчны тоогоор үнэлгээг гаргадаг.

Анги дэвших бүрт багийн ахлагч нар солигдон ажиллах ба эцэг эхийн зөвлөлийн гишүүд ч мөн солигдоно.

БАТЛАВ
СУРГАЛТЫН МЭНЭЖИГ *Т.МНДАГМАА*

1д ангийн Эцэг эхчүүдийн “Төлөвшил” багийн
ажлын төлөвлөгөө

2016-2017 оны хичээлийн жил

№	Ханрах хүрээ	Хийгдэх ажилууд	Хугацаа	Хариуцах эзэн
1	Эцэг эхчүүд	Бөгшөөг хамтран сурагчдын төлөвшилд өндөрлөх	Жилийн турш	Төлөвшил багийн эцэг эхчүүд
2		Сурагчдад ойгоомтой байсаар ангийн дэг боловсруулах	10 сард	Төлөвшил багийн эцэг эхчүүд
3	Сурагчдын анги	Үдлийн цайны дэгийг мөрдөх	9 сард	Төлөвшил багийн эцэг эхчүүд
4		Мэргэжлийн ажиллагааг зохиоход “Мөр уригдах” тэмдэг зохион байгуулах	2 сард	Төлөвшил багийн гишүүд
5		Ахмадын үндэс мөчлөг зохиоход сурагчдад өндөр амжилт	2 сард	Төлөвшил багийн гишүүд
6		Хүүхдийн зохиолчтой уулзуулах	4 сард	Эцэг эхчүүд ангийн багш

Төлөвлөгөө бичсэн: Багийн ахлагч Э.Зоригийн эвч Г.Зоригийн
Ангийн багш *Б.Бадмагалан* Б.Бадмагалан

БАТЛАВ
СУРГАЛТЫН МЭНЭЖИГ *Т.МНДАГМАА*

Эцэг эхчүүдийн “Авьяас”-ын багийн
ажлын төлөвлөгөө

2016-2017 оны хичээлийн жил

№	Ханрах хүрээ	Хийгдэх ажилууд	Хугацаа	Хариуцах эзэн
1	Эцэг эхчүүд	Сурагчдаас авьяасан судалгаа авах	Жилийн турш	Авьяас багийн гишүүд
2		Мэргэжлийн ажиллагааг зохиоход	10 сард	Авьяас багийн гишүүд
3		Шинэ жилийн өмнөдөө гаргах	12 сард	Авьяас багийн гишүүд
4	Сурагчдын анги	Тайланг уриалгаад бэлтгэх	11 сард	Авьяас багийн гишүүд ангийн багш
5		Түрэн хэлэлцэлийн ном хийх	1-р улиралд	Авьяас багийн эцэг эхчүүд
6	Сурагчдын анги	Мэргэжлийн ажиллагааг зохиоход	9 сард	Авьяас багийн гишүүд
7		Шууга, зүйс үг, ертөнцийн гурав хэлэлцүүлэх	Жилийн турш	Авьяас багийн гишүүд

Төлөвлөгөө бичсэн: Багийн ахлагч Б.Сүэд-Эрдэний эвч Цэцэг
Ангийн багш *Б.Бадмагалан* Б.Бадмагалан

✓ ҮР ДҮН

Эцэг эхчүүд өөрсдийн мэргэжил, сонирхол, чадварт тулгуурлан багуудад хуваагдан ажилласнаар үйл ажиллагаанд идэвхтэй, хариуцлагатай оролцож байгаа нь ажиглагдсан. Түүнчлэн эцэг эхчүүдийн хүүхдийнхээ хичээл, сурлага, хүмүүжилд хандах хандлага өөрчилөгдөж өөрийн нөөц бололцоог бүрэн дайчилж оролцдог болсон.

Эцэг эх, асран хамгаалагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэн ажилласнаар багш багшийн ажлын ачаалал багасч, эцэг эхчүүд сургалтын бүхий л үйл ажиллагаанд жигд оролцдог болсон.

👁️ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Эцэг эх бүрийн жигд оролцоог хангасан эцэг эхийн зөвлөлийн байгуулснаар сургууль, ангийн үйл ажиллагаанд идэвхи санаачилгатай, сайн дураар оролцдог болж байна.

Бүлгүүдийн эцэг эхийн зөвлөл, бага ангийн эцэг эхийн зөвлөлүүд шинээр байгуулагдан хамтран ажиллах бүтэц тогтолцоо шинээр үүссэн.

АМГАЛАН ЦОГЦОЛБОР СУРГУУЛЬ



САЙН ТУРШЛАГА

Цэцэг ургуулах аян



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ СУРГУУЛЬ

БЗД-ийн Амгалан цогцолбор
сургуулийн бага багш
Б.Алтантуяа



ХАРИУЦАХ АЖИЛТАН

Анги удирдсан багш

ЗОРИЛГО

Цэцэг ургуулах аргыг сургалтын үйл ажиллагаанд ашиглан эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх



АРГАЗҮЙ

Эцэг эх, сурагчдыг хамтад нь хөгжүүлэх, урамшуулах, үнэлэх, идэвхжүүлэх зорилгоор **Цэцэг ургуулах аргыг хэрэгжүүлж** ажиллалаа. Тус аргыг хичээлийн жилийн улирлын онцлогт тохируулан өөр өөр нэрээр хэрэгжүүлэн ажилласан нь хүүхдүүд эцэг эхчүүдэд их сонирхолтой байсан. Тухайлбал, намрын улиралд “**Сагс дүүрэн жимс бидний амжилт**”, өвлийн улиралд “**Сүлд модоо чимэглээрэй**”, хаврын улиралд “**Цэцгээ ургуулъя**” гэх мэт аян болгон зохион байгуулж, үр дүнг нь эцэг эхийн зөвлөлийн гишүүдтэйгээ хамтран дүгнэсэн. Дээрх сэдвийн дагуу ангид самбар хийж байрлуулан эцэг эхчүүдийн ангийн ажилд оролцох бүрт нэг навч, таван хошуу, жимс зэргийг нэмж наана. Улирлын эцэст хэний эцэг эх их идэвхтэй сайн оролцсоныг дүгнээд ангийн эцэг эхийн хурал дээр урамшуулж, сайн туршлагаас нь хуваалцдаг. Түүнчлэн ангийн сурагчдын уралдаан тэмцээний оролцож шалгуур үзүүлэлтэд **эцэг эхийн оролцоог** нэмж дүгнэдэг болсон.

Дээрх аргыг хэрэгжүүлж байх явцад хийсэн сагс, сүлд модоо хүүхдийн нүдэнд харагдахуйц байрлуулна. Үүнээс хүүхэд эцэг эхийнхээ оролцсон байдлыг таван хошуу, цэцгийн дэлбээ, навчны тооноос харж дүгнэдэг эцэг эхчүүдээ илүү оролцохыг шаарддаг. Мөн эцэг эхчүүд өөрсдийгөө бусадтай харьцуулан дүгнэж идэвх чармайлт нь нэмэгддэг.



ҮР ДҮН

Цэцэг ургуулах аяныг өрнүүлснээр дараах үр дүнд хүрсэн.

- Эцэг эхийн оролцоо сайжирч, тэдний хүүхдэдээ хандах хандлага өөрчлөгдсөн.
- Сурагчид ээж ааваараа бахархаж өөртөө илүү итгэлтэй болсон.
- Хүүхдийн сурлагын амжилт нэмэгддэг.
- Хүүхэд өгсөн үүрэг даалгаврыг тогтмол цаг хугацаанд нь биелүүлдэг дадалтай болсон.
- Хүүхдийн сэтгэлзүй, төлөвшилд эерэг хандлага гардаг.
- Хүүхэд хичээлд идэвхтэй оролцож мэрийдэг.
- Эцэг эхчүүд үүргээ ухамсарлан сургуулийн үйл ажиллагаанд байнга идэвхтэй оролцож байна.
- Сургуульд үзүүлэх эцэг эхийн дэмжлэг нэмэгдсэн.
- Багшийн ажлын ачаалал буурсан.



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Энэ аргазүйг цаашид анги дэвших тутам хэлбэр, аргазүйг өөрчлөн тогтмол ашиглах боломжтой юм.



Save the Children

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар

☎ +976-11-329365, +976-11-329371

📠 +976-11-329361

✉ secretary@savethechildren.mn

🌐 www.savethechildren.mn

📘 Save the Children in Mongolia

🐦 Save the Children MN

© Гэрэл зургуудын эрхийг Хүүхдийг Ивээх Сан эзэмшинэ.